



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.09.16, ДАВАА ~ №157 (1208)

~ МОНГОЛ ХҮН БҮР БАЯЖИГТУН ~

ҮНЭ: 1000Т

У.Хүрэлсүх: Улаанбуудайн урамшууллыг 50 хувиар нэмэгдүүлнэ

Улаанбуудайн урамшууллыг тонн тутамд нь 50 мянган төгрөгөөр тооцон олгож ирснийг нэмнэ. >2

Нийслэлчүүд амар тайвныг мэдэрсэн өдөр

Автомашингүй өдөр агаарын бохирдлын эсрэг нэгдэхийг уриалав >6

Урсгал дансны алдагдлыг бууруулах шаардлагатай

Энэ оны эцэст төлбөрийн тэнцэл бага зэрэг ашигтай гарах төлөвтэй. >11

FULL ENGLISH PAGE INSIDE

ZGM DAILY >7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Ерөнхийлөгч Х.Баттулга "Итгэл найдвар, боломж – УБ 2019" бүх нийтийн марафонд оролцов.
Өнөөдөр Ёс зүйн дэд хороо хуралдаж, гишүүдийн ёс зүйн асуудлыг хэлэлцэнэ.
Засгийн газрын нээлттэй өдөрлөг өнөөдөр эхэлж, үйл ажиллагаагаа нийтэд таниулна.
Намрын чуулганаар нийт 28 асуудал хэлэлцэхээр УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл батлав.

ЭДИЙН ЗАСАГ
Мөнгөний нийлүүлэлт наймдугаар сард 20.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өслөө.
Нүүрсний экспорт энэ оны эхний найман сард 25 сая тонн хүрсэн байна.
"Сүү" 2018 оны ашгаасаа нэгж хувьцаанд 73.33 буюу нийт 71.1 тэрбумыг ногдол ашиг тараана.
Топ 20 индекс 1.2 хувиар өсөж, 19477.47 нэгжид хүрсэн байна.



НИЙГЭМ
Сайжруулсан түлшийг өчигдрөөс эхлэн картаар олгож эхэлсэн байна.
Улаанбуудайн тонн тутамд олгодог урамшууллыг 50 хувиар нэмж, 7100 мянга болгов.
Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг Хурхын шар тал хэмээх газар баавгай орж иржээ.
Замын цагдаагийн гүүрэн гарцын үндсэн хөдөлгөөнийг өнөөдөр нээв.

ДЭЛХИЙ
Британийн ЕС Жонсон гэрээгүй Брекситийн хориглох парламентын шийдвэрийг шүүхэд өгнө.
Хонконгт эсэргүүцлийн хөдөлгөөн үргэлжлэхийн сацуу дэлүүний баяр болсон байна.
Филиппиний нийслэлд гахай олноор үхсэний улмаас гахайн чичиргээ өвчний хяналтыг чангатгав.
Стэнфордын их сургууль амиа хорлосон тэрбумтан Ж.Эпштейнээс \$50000 хандив хүлээн авчээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2019.09.16

16° | 3°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРНИЙГ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС ҮНШИНЭ ҮҮ.

8 658 000 029 112 0 120 8

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©



Хүүхдийн эмч хүрэлцээгүй байхад хүн амын өсөлт яриад ч хэрэггүй

Нэг хэсэг Улаан номонд орох шахтлаа цөөрөөд байсан хүүхдийн эмчийг бодлогоор бэлдсэний ачаар нөхцөл байдал харьцангуй дээрдсэн. Гэвч бэлтгэгдэж төгссөн боловсон хүчнээ ажлын байраар хангаж чадахгүй байгаа тул хүүхдийн эмчийн эрэлт хэрэгцээ урьдын адил их хэвээр байна. >3

УЛС ТӨР "Монголын ардчиллын амин сүнс нь зөвшилцөл"

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

оллолт, алдаа оноо, тулгарч буй бэрхшээл сорилтыг дунд, залуу үеийнхнээрээ дүгнүүлсэн нь ололтой байв.

Хурлын модератороор ардчилсан хувьсгалын анхдагчдын нэг, эдийн засагч Р.Амаржаргал, УИХ-ын гишүүн, МАН-ын залуучуудын байгууллагын тэргүүн Н.Учрал нар ажилласан нь бас содон хошил байсан.

Эдийн засагч Р.Амаржаргал 230 жилийн өмнө өрнөсөн Францын ардчилсан хувьсгалыг дүгнэх болоогүйг мэргэчүүл нь хэлдгийг эш татаад, 30 настай Монголын ардчиллын алдаа оноог ярихад эрт байна гэв.

▶ 2

ДЭЛХИЙ Саудын нефтийн үйлдвэрүүд рүү дайрсанд Ираныг буруутгав

Надим Хамид

АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Майк Помпео Саудын Агаасо компанийн нефтийн байгууламжууд руу хийсэн дайралтыг Йемен үйлдсэн гэх нотолгоо алга хэмээн Ираныг буруутгажээ. Ерөнхийлөгч Дональд Трамп Саудын ван Мохаммед Бин Салмантай бямба гарагт утсаар ярьж, Саудын Арабыг өөрийгөө хамгаалахад туслалаа илэрхийлсэн гэж Цагаан ордон мэдэгдсэний дараа ноён Помпео твиттертээ Тегераныг буруутган жиргэсэн байна.

Тэрбээр "Иран дэлхийн эрчим хүчний нийлүүлэлтэд урьд үзэгдээгүй цохилт өглөө" хэмээн бичжээ. Түүнчлэн Бүгд найрамдах намын нэг хууль тогтоогч Ираны нефтийн байгууламжуудад адил цохилт өгөх ёстой хэмээн уриалав. Төрийн нарийн бичгийн дарга АНУ холбоотнуудтайгаа хамтран эрчим хүчний зах зээлийн хангалтыг хэвийн байлгахыг баталгаажуулна гэжээ. Тэрбээр улс орнуудад хандаж, "Ираны халдлагыг нийтээр, нэгэн санаагаар буруушаахыг" уриаллаа.

▶ 9

ЗГМ: ИНФОГРАФИК

Монголчуудын цалин хэд вэ

Аж ахуй нэгж, байгууллагын ажиллагчид (цалин хөлсний бүлгээр, дүнд эзлэх хувиар)

Медиа цалин 827,821₮ | Дундаж цалин 1,157,879₮

₮320,000 хүртэл	9.7%	900,001-1,300,000	22.5%
320,001-500,000	13.0%	1,300,001-1,500,000	5.5%
500,001-900,000	32.6%	₮1,500,001 дээш	16.7%

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2019 оны 1 дүгээр улиралд

40.6 мянган Аж ахуйн нэгж, байгууллага | 643.2 мянган Ажиллагчид хамрагдсан

Аж ахуй нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин (байгууллагын хариуцлагын хэлбэрээр, мянган төгрөг)

Төрийн өмчит үйлдвэрийн газар	1449.9	Хоршоо	548.5
Төрийн бус байгууллага	910.7	бусад	9.3
Хувьцаат компани	1324.9	Ажиллагчдын эзлэх %	45.9
Төсөвт байгууллага	914.7	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1278.7
			27.0

ҮСХӨ

ЭДИЙН ЗАСАГ Гадаад өрийн зөрүүтэй мэдээлэл эргэлзээ үүсгэж байна

Б.Баяртөгтох
@bayartogtokhZGM

“Эрх баригч МАН 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөртөө “Эх орноо өрнөөс салгана...” гэсэн цагаан цаасан дээр тод улаанаар бичсэн амлалт дурайна. Нэг хүнд ногдох өрийн хэмжээ 15 сая төгрөгт хүрч, улсын нийт өр 22 тэрбум ам.доллар гэж өнөөдрийн засаг төрийг эмхлэх улс төрийн ууган хүчин гурван жилийн өмнө хойш тугмын нэг нь ядуу амьдарч байна. Өрийн хэмжээ харин өөрчлөгдсөн зүйлгүй. Дээр дурдсан нэг хүнд ногдох өр өнгөрсөн гурван жилийн хугацаанд 2.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 17.3 сая төгрөг болсон байна. Өрнөөс салгана гэсэн улстөрчид хэлсэн ярьснаа харин мартсан бололтой.

“Өрийн гүн ангал руу орлоо” гэж ярьж суусан МАН 2016 оноос хойш өр нимгэлж ердийлсэнгүй. Харин ч Дэлхийн банкны судалгаагаар бизнесийн орчин муудаж, 12 байр ухарсан бол авлига нэмэгдэжээ. Авлигын индексээр Монгол Улс 175 орноос хойш шийдэгдэж, 103-т нь эрэмбэлэгдэв.

▶ 12

АЛТ 1,499.50 0.52%	ЗЭС 5,974.50 2.43%	10-ЧИНГИС БОНД 98.700 0.13%	ХУРАЛДАЙ БОНД 110.70 0.12%	ГЭРЭГЭ БОНД 99.330 0.12%	АМ.ДОЛЛАР 2,670.87	ЮАНЬ 377.27	РУБЛЬ 41.42
---------------------------------	---------------------------------	--	---	---------------------------------------	------------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

“Монголын ардчиллын амин сүнс нь зөвшилцөл”

Ардчилал бидэнд юу өгснийг залуусаар дэнслүүлэв

◀1

Тэрбээр “Монголын ардчиллыг Ардчилсан нам хэзээ ч өмчилж байгаагүй. Энэ бол монголчуудын хамтын бүтээл. Монголын ардчиллын амин сүнс нь зөвшилцөл байсан. Ардчилал гэдэг америкчуудад нэг өөр. Япон ч юм уу өөр улсуудын хувьд бас ондоо. Харин монголчуудын хувьд ардчилал гэдэг дөрвөн жилд болдог сонгууль, олны өмнө гарч ирээд цээжээ дэлдэж орилдог популизм, жендерийн тэгш эрх энэ тэрийг зарлан тунхаглах тухай биш юм. Харин Монголын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын баталгаа нь ардчилал юм” хэмээв.

Харин илтгэгчдээр дипломатч Ц.Сүхбаатар, Социал-демократич олон улсын эмэгтэйчүүдийн байгууллагын Ази номхон далайн бүс хариуцсан дэд ерөнхийлөгч Д.Энхжаргал, Үндэсний брэндийн зөвлөлийн тэргүүн Н.Дэмбэрэл, LEAD хөтөлбөрийн төсгөгч, судлаач Г.Булганчимэг, эдийн засагч О.Эрдэнэ-Өрнөх нар оролцсон юм. Тэд Монголд өрнөсөн ардчиллын ололт хийгээд сорилтыг хэрхэн тодорхойлсныг тоймлон хүргэв.

Ц.СҮХБААТАР:
Дипломатч/
АРДЧИЛСАН ХУВЬСГАЛААР МОНГОЛ ОРОН ОБЪЕКТООС СУБЪЕКТ РҮҮ ШИЛЖСЭН
Миний бие 1980-аад оноос гадаад харилцааны салбарт ажилласан. Тухайн үед ЗХУ болон социалист нөхөрлөлийн орнуудын эрх ашгийг хамгийн эхэнд тавьдаг, Монгол өөрөө

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуудагга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатар ДАЛГАЯА

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжаах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgmn.mn
ubinfo.mn
Дуугаарын удирдагч
Б.Энхжаргал

8663800042912 01209



ЗГМӨ

бие даасан бодлого хэрэгжүүлэх боломжгүй байлаа. Цөөн хэдэн улстай харилцааг, гадагшаа явахдаа социалист чиг баримжаатай орнууд руу л явна. Өөрсдийгөө азид буй коммунизмын гол тулгуур гэж үздэг, ЗХУ-ын 100 мянга гаруй бие бүрэлдэхүүнтэй цэргийн хамгийн хурдан олон салбар байдалтай 1990 онтой золгосон. Монголд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнд зүг чигээ хамгийн хурдан олсон салбар бол гадаад харилцааны салбар. Тэр үед Монголыг эдийн засгийн хувьд тэжээж байсан ЗХУ нуран унаснаар манай орон эдийн засгийн гүн гүнзгий хямралд орсон. Тиймээс тухайн үеийн Ерөнхийлөгч П.Очирбат болон гадаад харилцааг ахалж явсан Ц.Гомбосүрэн, эдийн засагч Да.Ганболд нар маш зөв бодлого хэрэгжүүлж, “Монголд хандивчлагчдын чуулган” гэх бүтцийг өндөр хөгжилтэй орнуудын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Энэ нь улс төр, эдийн засгийн өөрчлөлтийг хийх боломжийг бий болгосон. Товчхондоо ардчилсан хувьсгалаар Монгол Улс объектоос субъект рүү шилжсэн.

Н.ДЭМБЭРЭЛ:
Үндэсний брэндийн зөвлөл/
АРДЧИЛСАН ЧӨЛӨӨТ БОДЛОГОО ХЭРХЭН АВСАА ШИЙДЭХ

ЗАСГИЙН ГАЗАР

У.Хүрэлсүх: Улаанбуудайн урамшууллыг 50 хувиар нэмэгдүүлнэ

Б.Сэлэнгэ
ЗГМ

Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, БОХХАА-н байнгын хорооны дарга Х.Болорчулуун нар амралтын өдрүүдэд газар тариалангийн бүс нутаг Төв, Сэлэнгэ аймагт ажиллажээ. Энэ онд улсын хэмжээгээр 364.8 мянган га-д үр тариа, үүнээс 340.1 мянган га-д улаанбуудай, 14.8 мянган га-д төмс, найман мянган га-д хүнсний ногоо, 82.4 мянган га-д тосны, 42.0 мянган га-д тэжээлийн ургамал, нийтдээ 512.0 мянган га-д тариалалт хийсэн юм. Урьдчилсан балансаар 441.9 мянган тонн үр тариа, үүнээс 420.0 мянган тонн буудай, 176.8 мянган тонн төмс, 91.2 мянган

ТҮҮХЭН ҮЕ ИРЛЭЭ
Өнөөдөр дэлхий нийтээр дахин нэг тектоник хөдөлгөөн явж байна. Угаасаа Евразийн энэ хэсэгт дэлхийд бодлогоо хэрэгжүүлдэг геополитик байна. Энэ онолын дагуу их гүрнүүд хоорондоо өрсөлдөж байгаа. Гэхдээ одоо хоорондоо дайтаад явахгүй нь тодорхой. Харин эдийн засаг, улс төр, дипломат бодлого явуулж байна. Дэлхий даяар өрнөж буй эдийн засаг, геополитикийн орчинд Монгол Улс 300 жилд анх удаа өөрсдөө авч явж буй ардчилсан чөлөөт бодлогоо хэрхэн үргэлжлүүлэх вэ гэдэг түүхэн цаг үе ирлээ гэж хардаг. Гэтэл хувь заяаны шоглоом ч гэдэг юм уу, яг энэ хугацаанд засаглал солих хэмжээнд хүртэл улс төр яригдаж байгаа бүгд харж байна.

О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ:
Эдийн засагч/
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ ТОГТОЛЦООГ ХУУЧНААРАА УДИРДАХ ГЭСЭН АРГА БАРИЛ БАЙСААР БАЙНА

Эдийн засагт хувийн хэвшил давамгайл болсон, худалдаа нээлттэй болсон, Дэлхийн худалдааны байгууллагад элссэн, санхүүгийн хямралуудыг давж гарсан гээд ардчиллаас хойш Монголын эдийн засгийн салбарт гарсан ахиц дэвшил их. Гэхдээ бидний өмнө сорилтууд

байна. Хамгийн түрүүнд ядуурлыг хэлмээр байна. Дэлхийн банкны үзүүлэлтээр 2018 онд хүн амын 28 хувь нь ядуу байна. Өөрөөр хэлбэл ядуурлын түвшин хэт өндөр. Нөгөө тал дээр орлогын ялгаатай байдлын үзүүлэлт ч мөн хэт өндөр. Түүнээс гадна ДНБ дэх төсвийн зарлагын жин тогтмол 30-аас дээш байна. Заримдаа 40 хүрдэг. Энэ бол орлогын ялгаатай байдал, ядуурал ихтэй, эдийн засаг дахь төрийн оролцоо давамгайл хэвээрээ байгаагийн илрэл. Хэдийгээр манай хувийн хэвшил либеральчлагдаж, өнөөдрийн зэрэгтэй явж байгаа ч өмнөхөө санагалздаг, шинэ тогтолцоог хуучнаараа удирдах гэж оролддог байдал төрд байсаар байна. Өөрөөр хэлбэл эдийн засаг дахь сэтгэлгээний өөрчлөлт хийгдээгүй байгаа юм. Цаашид эдийн засгийг удирдах гэж оролдож байгаа, бизнесийн орчныг сайжруулах гээд муутгаж байгаа хуучинсаг, зөвлөлт маягийн арга барилаа өөрчлөх нь хамгийн чухал.

Г.БУЛГАНЧИМЭГ:
Судлаач/
МОНГОЛЧУУД ТЭГШ БУС БОЛОМЖИЙГ ЭДЭЛДЭГ
Өнөөдөр Монголын нийгэм яагаад ийм их бухимдалтай, ардчилсан тогтолцоогоо буцааж хэмжээний эргэлзээ үүсчихэв ээ гэдэг нь гол асуулт. Миний

бодлоо иргэдэд нийгэм, эдийн засгаа сайжруулах боломж нь хангалттай үүсээгүй байна. Энэ боломж үүсэхгүй байгаа хамгийн том шалтгаан нь ерөөсөө л тэгш зүгээр нэг эрх мэдэлтэй айлын хүүхэд ямар амархан олж авсныг таамаглаж байгаа асуудлыг шийдэж байна. Цоо шинээр “тэнгэрээс бууж ирсэн” нэг ч асуудал байхгүй. Одоо энэ төслөө ард нийтгээсээ асуухаар шийдвэрлээ. Энэхүү “Ард нийтийн санал асуулга” бол засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх Үндсэн хуулиар олгогдсон иргэний онцгой эрхийг 1945 оноос хойш анх удаа хэрэгжүүлж гэж байгаа түүхэн үйл явдал юм. *УИХ-ын дарга Г.Занданшатар*

ЗГМ ТОВЧХОН

» ТОО

28

УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл баасан гарагт хуралдаж, намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг баталжээ. Уг дарааллаар нийт 28 асуудлыг ирэх намрын чуулганаар хэлэлцэхээр болж байна.

» ӨДӨРЛӨГ

Өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах нээлттэй өдөрлөг Сүхбаатарын талбайд эхэлнэ. Энэ өдрүүдэд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг танилцуулж, иргэдэд мэдээ, мэдээлэл өгөх бөгөөд яам, агентлагууд салбарынхаа ажлыг сурталчлан, хариуцсан чиглэлээрээ төрийн зарим үйлчилгээг хүргэх юм.

» ШАГНАЛ

Япон улсын Гадаад хэргийн сайдын өргөмжлөлийг жил бүр Япон болон Монгол Улсын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллага хамт олонд олгодог. Энэ жилийн өргөмжлөлийн эздээр Монгол Улсад Япон маягийн техникийн коллежийг таниулан дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан Боловсролын сайд асан Л.Гантөмөр, Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч Ц.Байгалмаа нарт гардуулла.

ЭШЛЭЛ



Сүүлийн таван парламент дамжин яригдаж, түүний гурван парламентад нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон өргөн баригдаж хэлэлцэгдсэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн эхийг энэ удаагийн УИХ хэлэлцэн баталлаа. Энэ бол парламентын засаглалаа бэхжүүлэх зорилготой хийгдсэн томоохон өөрчлөлт гэдэгт эрдэмтэн судлаачид санал нэгдэж байгаа. Арав гаруй жил яригдаж байгаа асуудлыг шийдэж байна. Цоо шинээр “тэнгэрээс бууж ирсэн” нэг ч асуудал байхгүй. Одоо энэ төслөө ард нийтгээсээ асуухаар шийдвэрлээ. Энэхүү “Ард нийтийн санал асуулга” бол засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх Үндсэн хуулиар олгогдсон иргэний онцгой эрхийг 1945 оноос хойш анх удаа хэрэгжүүлж гэж байгаа түүхэн үйл явдал юм. *УИХ-ын дарга Г.Занданшатар*

Сайд гишүүдийг Ёс зүйн дэд хороогоор хэлэлцэнэ

Баасан гарагт болсон УИХ-ын чуулганы хуралдааны үеэр Засгийн газрын сайд нар картаа сугалж, хурлын үйл ажиллагааг тасалдуулсан юм. Учир нь Шадар сайдын өргөн мэдүүлсэн зээлийн хэлэлцээрийг Байнгын хороо болон чуулганы хуралдаанаар хэлэлцээгүй учраас Шадар сайд Ө.Энхтүвшин Засгийн газрын сайд нараа картаа сугалахыг үүрэг болгосон аж. Өөрөөр хэлбэл, Засгийн газраас өргөн мэдүүлсэн асуудлыг парламентаар хэлэлцээгүйн төлөө УИХ-ын чуулганы ирцийг бүрдүүлэхгүй байх шийдвэрийг зарим сайд гишүүн гаргасан нь энэ аж. Тиймээс УИХ-ын дарга Г.Занданшатар хурал үймүүлсэн сайд нарыг Ёс зүйн дэд хороогоор авч хэлэлцэхийг үүрэг болгосон байна. Тэгвэл энэ долоо хоногийн хэлэлцэх асуудлын дараалалд Ёс зүйн дэд хорооны хуралдаан багтжээ. Өнөөдөр 16.00 цагаас болох уг хуралдаанаар “Гишүүдийн ёс зүйн асуудлыг хэлэлцэнэ” хэмээн хуваарь гаргасан байв. [ЗГМ]



тонн хүнсний ногоо, 38.0 мянган тонн тосны ургамал, 80.4 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авах боломжтойг ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан хэллээ. ХХААХҮ-ийн сайдын танилцуулснаар, энэ жилийн хувьд Булган, Хөвсгөл, Орхон, Архангай, Өвөрхангай, Увс болон Сэлэнгэ

нөхцөл байдалтай уялдуулж технологийн зөвлөмжийн дагуу шуурхай зохион байгуулж улаан буудайн хэргэгцээг дотоодоосоо бүрэн хангах боломжтой юм байна. Энэ жил улсын хэмжээнд 340 мян га-д үр тариа тариалсан бөгөөд 400 мянга орчим тонн улаанбуудай хураахаар төлөвлөжээ. Ерөнхий сайд У.Хүрэлсүх, стратегийн хүнсний бүтээгдэхүүн гурилын үнийг тогтвортой байлгах, хангамжийг сайжруулах үүднээс улаанбуудайн урамшууллыг тонн тутамд нь 50 мянган төгрөгөөр тооцон олгож ирснийг нэмнэ гэж мэдэгдэв. Энэ жилийн нөхцөл байдал тариаланчдын хүсэлтийн дагуу улаанбуудайн урамшууллыг 50 мянган төгрөгөөр нэмж, 100 мянгад хүргэнэ гэдгээ Төв аймгийн Утгаалцайдам сумын тариаланчидтай уулзахдаа хэлсэн юм. [ЗГМ]

Нийтлэлчийн булан

Өрхийн эмнэлгийн эмч нарын 30 хүрэхгүй хувь нь хүүхдийн эмч мэргэжилтэй

Г.Баярсайхан
ЗГМ

1996 онд тухайн үеийн АУИС хүүхдийн эмч бэлтгэдэг ангиа хааснаар энэ мэргэжилтэн Улаан номд орох шахтлаа цөөрсөн түүх бий. 1990-ээд оноос хойш төрөлт багассан нь хүүхдийн эмчийг “ад үзэх” шалтгаан болжээ. Гэвч он цагийн уртад улсын хүн ам өсөж, тэр дунд хүүхдийн эзлэх жин нэмэгдэхийн хэрээр хүүхдийн эмчийн хэрэгцээ, шаардлага дахин бий болсон юм. Улмаар 2010 оноос одоогийн АШУУИС-д хүүхдийн эмчийг резидентураар



Өдгөө нийт 218 өрхийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. Гэвч иргэд өрхийн эмнэлгээр үйлчлүүлэх тийм ч дуртай биш. Өвчнөө оношилж мэддэггүй, эмч нар нь дадлага туршлага багатай гээд өрхийн эмнэлгийг өөлж муучлах хүн олон. Үүний учир шалтгаан мөнөөх л хүүхдийн эмчтэй холбогддог.

С.Батсайхан / ЗГМ ©

Хүүхдийн эмч хүрэлцээгүй байхад хүн амын өсөлт яриад ч хэрэггүй

сургадаг болсноос хойш байдал харьцангуй дээрджээ. Гэвч хонх нь дугарахаар дамар нь таг гэдэг шиг хүүхдийн эмч хэрэгтэй байна гэж баахныг бэлтгэж гаргасан атал тэдэнд зориулсан ажлын байр хомс хэвээр байгааг мэргэжилтнүүд ярьж байна. Тиймээс хүүхдийн эмч мэргэжил эзэмшсэн хүмүүс өөр чиглэлээр ажиллах нь түгээмэл болжээ.

“Одоо жилд 50-иад хүн хүүхдийн эмчээр төгсөж байна. Эндээс харвал хүүхдийн эмч жигтэйхэн хүрэлцээтэй болсон мэт. Гэтэл тийм биш. Хүүхдийн тоо өссөн ч норматив нь сая гаруйхан хүнтэй байх үеийнхээрээ. Нэг ёсондоо ажлын байраараа л цомхотгочихоод байна гэсэн үг. Үүнээс болж мэргэжлээрээ ажиллаж чадахгүй эмч маш олон болсон. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн нярайн тасаг гэхэд 46 орны нормтой, түүндээ тохирсон эмчтэй. Гэвч 100 гаруй эх байнга хэвтэн эмчлүүлдэг. Нэг эмч 2-3 хүний ажлыг хийж байна” хэмээн хүүхдийн эмч мэргэжлээр 50 гаруй жил ажиллаж буй ардын эмч Д.Малчинхүү ярьв.

Өдгөө Монгол Улсын хүн амын 35 орчим хувийг 0-18 насны хүүхэд эзэлж байна. Олон улсын дундажтай харьцуулбал энэ бол тун өндөр тоо. Гэхдээ хүүхдийн орон гэгдсэн Монголд хүүхдийн эмч одоо болтол дутагдалтай байгаад санаа тавьдаг, анхаарлаа хандуулдаг эрх мэдэлтэн, албан тушаалтан үгүй бололтой.

Намрын сэрүү орж, өдрөөс өдөрт хүйтэрч байна. Удахгүй гэр хорооллын 200 мянган өрх галаа түлээд эхлэхээр цээж хорсгосон гашуун утаа нийслэлийг бүрхэнэ. Энэ цаг үетэй зэрэгцээд хүүхдүүд бөөн бөөнөөрөө ханиад, хатгаанд нэрвэгдэж, эмнэлгийн ачааллыг эрс нэмдэг. Гэвч балчир үрсэд үйлчлэх ор хүрэлцээгүй, эмч нар дутагдалтай байдал өмнө нь байсан, одоо ч хэвээрээ.

“Монгол Улсад нийт 10576 эмч ажиллаж байна. Гэтэл хүн амын 36.5 хувьд нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хүүхдийн эмчийн тоо 741 буюу ердөө долоон хувийг эзэлдэг. Энэ нь хүүхдийн эмчийн эрэлт хэрэгцээ ямар их байгааг харуулж байна” хэмээн АШУУИС-ийн захирал Ж.Долмон хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр ярьж байв.

Хүүхэд нь өвдөж зовсон үед эцэг эхчүүд хамгийн түрүүнд өрхийн эмнэлэгтээ хандах ёстой. Эмнэлгүүдийн ачааллыг жигд байлгахын тулд салбарын яамнаас ийм бодлого барьж, өдгөө нийт 218 өрхийн эмнэлэгтэй болоод байна. Гэвч иргэд өрхийн эмнэлгээр үйлчлүүлэх тийм ч дуртай биш. Өвчнөө оношилж мэддэггүй, эмч нар нь дадлага туршлага багатай гээд өрхийн эмнэлгийг

өөлж муучлах хүн олон. Хүүхэд нь хатгаа тусчихаад байхад өрхийн эмч нь мэдэхгүй элдэв янзын эм бичиж өгсөөр байгаад улам хүндрүүлсэн гэх яриаг олон хүний амнаас сонссон байх. Үүний учир шалтгаан мөнөөх л хүүхдийн эмчтэй холбогддог. Өдгөө өрхийн эмнэлэгт ажиллаж буй эмч нарын 30 хүрэхгүй хувь нь хүүхдийн эмч мэргэжилтэй гэсэн багцаа тоо бий. Уг нь өрхийн эмнэлгээр хүүхэд, хөгшчүүд голдуу үйлчлүүлдгийг бодолцоод ажилгүй байгаа хүүхдийн эмч нарыг тэнд бодлогоор хуваарилмаар санагддаг юм. Гэвч салбарын яам энэ бүх зовлонг мэдээгүй мэт нүдэн балай, чихэн дүлий суусаар.

хүүхдийн суурь өвчнийг маш сайн хянадаг байж. Харин одоо өрхийн эмнэлгүүдэд дандаа ерөнхий мэргэжлээр төгссөн эмч нар ажилладаг болсон учраас хүүхдийн тусламж, эмчилгээ чанарын хувьд доройтсон. Уг нь хүүхдийн тоо өсөхийн хэрээр хүүхдийн эмч нарыг ажлын байраар хангамаар байгаа юм. Өрхийн эмнэлэгт даралтаа үзүүлдэг хэдэн хөгшчүүд болон хүүхдүүд л үйлчлүүлж байгаа шүү дээ. Тиймээс өрхийн эмнэлэг бүрт дор хаяж нэг хүүхдийн эмч ажиллуулдаг болох хэрэгтэй” хэмээн Д.Малчинхүү эмч бодлоо

хуваалцсаныг энд сануулья.

УИХ-ын Тамгын газрын судалгааны хэлтсээс хийсэн нэгэн судалгаа байна. Хэдийгээр 2016 оны судалгаа ч гэсэн тоо баримтууд нь нэг их хуучраагүй байх. Тус судалгаанд “Өнөөдрийн байдлаар нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 789 хүүхдийн орон дээр 78 их эмч, 86-90 сувилагч ажиллаж байна. Үүнийг нэгдсэн эмнэлгийн стандарттай харьцуулан үзвэл 40-50 их эмч, 30-40 хүүхдийн сувилагч нэн шаардлагатай байна” хэмээн дурджээ.

Мөн судалгааны дүгнэлтэд

“Эх барих эмэгтэйчүүд, нярай, эрчимт эмчилгээний эмч, эх баригч, сувилагч нарын ажлын ачаалал их, хөдөлмөрийн үнэлэмж хангалтгүй, урамшуулал бага, хариуцлага тооцох хэлбэр давамгайлж байгаагаас эмч нар ажлаас хөндийрч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага уруу шилжсэнээр бэлтгэгдсэн боловсон хүчнээ алдаж байна” хэмээжээ. УИХ-ын түвшинд томоохон хэмжээний даацтай судалгаа хийсэн нь сайн хэрэг. Гэвч судалгаанаас гарсан зөвлөмжийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэх ажил орхигдсон

нь хий дэмий хөрөнгө мөнгө зарцуулсан ажил болжээ.

Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас хаана л бол хаана хүүхэд, нялхсын эндэгдэл, өвчлөлийг бууруулах талаар том зорилт тавьж байгаагаа тунхаглан зарладаг. Харин тусгайлан эмчгүй байж ийн тунхаглах нь хоосон цуурай, хүн ардаа “хулхидсан” хууран мэхлэлт гэж хэлэхээс аргагүйд хүрч байна. Хүүхдийн эмч нь дутагдсан, балчир үрс нь өвчинд нэрвэгдсэн өнөөгийн нөхцөлд хүн амын өсөлт ярих хэрэг байна уу. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА

● **Хүн амын 36.5 хувьд нь эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хүүхдийн эмчийн тоо ердөө долоон хувийг эзэлдэг.**

● **Жилд хамгийн багадаа 50 гаруй хүүхдийн эмч бэлтгэгдэж байна. Харин бэлтгэгдэж төгссөн боловсон хүчнээ ажлын байраар хангах асуудал хамгийн чухал болжээ.**

● **Өрхийн эмнэлгүүдэд дандаа ерөнхий мэргэжлээр төгссөн эмч нар ажилладаг болсон учраас хүүхдийн тусламж, эмчилгээ чанарын хувьд доройтсон гэв.**

“Нэг хэсэг хүүхдийн эмч мэргэжлээр дөрөв, тавхан хүн төгсдөг байсантай харьцуулахад байдал дээрдсэн. Одоо жилд хамгийн багадаа 50 гаруй эмч бэлтгэгдэж байна. Харин бэлтгэгдэж төгссөн боловсон хүчнээ ажлын байраар хангах асуудал хамгийн чухал. Хүүхдийн эмчгүй өрхийн эмнэлэг олон байна. Эдгээр эмнэлэгт хүүхдийн эмч нарыг ажиллуулмаар санагддаг. Хүүхдийн биений онцлог томчуудынхаас өөр. Тэдэнд түмэн янзын эмгэг илэрдэг. Энэ бүгдийг зөв оношилж эмчлэхэд хүүхдийн эмч зайлшгүй хэрэгтэй. Уг нь энэ асуудлыг салбар хариуцсан яам бодлогын хүрээнд шийдэж болмоор санагддаг” хэмээн ЭХЭМҮТ-ийн захирал Ш.Энхтөр хэлсэн юм.

“Өмнө нь өрхийн эмнэлгийн тогтолцооны үед хүүхдийн хэсэг гэж байлаа. Тэгэхэд



Сурталчилгаа



Э.Шинэбаяр: Улаанбаатар Хотын Банкны Бүтээгдэхүүн Хөгжлийн Хэлтсийн Захирал

АНХДАГЧИД АЧААНЫ ХҮНДИЙГ ҮҮРДЭГ

Үндэсний үйлдвэрлэлийг бид яагаад бодлогоор дэмжих ёстой талаар эхлээд та бодлоо хэлээч?

Дэлхий ертөнц үсрэнгүй технологийн ачаар өдрөөс өдөрт улам бүр ижилсэж байна. Бэстселлэр ном, Холливуудын киноны нээлтийг бид дэлхийтэй нэг зэрэг шахуу хийж байна. Өндөр хөгжилтэй улсын иргэдтэй адил хамгийн сүүлийн загварын Samsung, iPhone гар утас, зөөврийн компьютерийг ашиглаж байна. Тэгвэл энэ хурдацтай глобалчилалд үндэстнүүд ялгарч үлдэх ёстой юу, юугаараа бид ондооших вэ гэдэг асуудал өнөөдөр улс орнуудын өмнө тулгараад байна. Тэгвэл глобалчилалд ялгарч үлдэх нэг гарц бол нүүдэлчний соёл уламжлалд тулгуурласан Монгол хүний оюун санаагаар бүтээсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, түүнийгээ экспортонд гартал дэмжих нь банк санхүү, бизнесийн байгууллагуудын хийх зүйл гэж хардаг.

Нөгөө талаас зэсийн үнээс хамаарч савладаг жижиг эдийн засгийг маань солонгоруулж олон тулгуурт болгоход ч алсдаа нөлөөлөх боломжтой гэх мэт өөдрөгөөр харвал үндэсний үйлдвэрлэлийн олон давуу талуудыг дурдаж болно.

Иймд банк санхүүгийн байгууллагын хувьд та бүхэн оюуны өмчийг барьцаалан үндэсний үйлдвэрүүдэд зээл олгох болжээ?

“Үндэсний Үйлдвэрлэлийг Дэмжигч” уриатай ажилладаг манай банк энэ онд 20 жилийнхээ ойтой золгож байгаа гэхээр эртнээс л энэ чиглэлд алсын хараагаа чиглүүлж байсан гэж ойлгож болно. Үндэсний өв соёл, уламжлалаа дээдлэх үзэл сүүлийн үед залуучуудын дунд хүчээ авч байна, тэр хэрээрээ үндэснийхээ бараа бүтээгдэхүүнээ хэрэглэх нь илтэд нэмэгдэж, брэндүүдийн тоо ч өсч байна. Үүнийг орчин үеийн технологитой хослуулан өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох боломжийг манай бизнесийнхэн ч эрэлхийлж байна. Гагцхүү тэдний хувьд бусад бизнесүүдийн адил зах зээлд хангалттай нийлүүлэлт хийхэд санхүүгийн асуудал тулгардаг. Санхүүжилтийг банкууд олон төрлийн зээлээр шийдэж байгаа ч барьцаа хөрөнгийн асуудал үргэлж үүсдэг. Иймд “Оюуны өмч”-г эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжихийг зорьсон анхных нь манай Улаанбаатар Хотын Банк билээ. Өнөөдрийн импортыг орлох үйлдвэрүүд маань маргаашийн экспортлогч нар гэж бид хардаг.

“БАРААНЫ ТЭМДЭГ”-ИЙГ БАРЬЦААЛАН ЗЭЭЛ ОЛГОЖ БАЙГАА МОНГОЛЫН АНХНЫ БАНК ЮМ.

Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудал олон жилийн турш «жижүүрийн яриа» байсаар ирсэн. Яаж бодит ажил болгов?

Бид оюуны өмчийн газраар баталгаажсан “Барааны Тэмдэг”-ийг барьцаалан зээл олгож байгаа Монголын анхны банк юм. Оюуны өмчийг бодитоор эргэлтэнд оруулах хүч нь одоогоор банк санхүүгийн байгууллагад л байна. Анхдагчид ачааны хүндийг үүрдэг жамтай. Бид олон талаас харж, гадаад дотоодын олон бизнес кэйс жишээг судалсаны үндсэн дээр “Барааны тэмдэг”-г барьцаалж жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл олгож эхэлсэн. “Барааны тэмдэг” бол тухайн хувь хүн, бизнесийн байгууллагын бий болгосон брэндийн нэр хүнд, гол үнэ цэнэ нь юм.

Барааны тэмдэгийг барьцаалан зээл олгож байгаа Монголын анхны банк гэхээр энэ тал дээр нэлээд туршлага хуримтлуулж байгаа байх. Энэ зээлийнхээ онцлогийг дурдаач?

Ийм төрлийн зээл анх барууны өндөр хөгжилтэй оронд 1997 онд нэвтэрсэн байдаг. Манай урд хөрш гэхэд 5 жилийн өмнөөс үүнд анхаарлаа хандуулж ирсэн гэхээр харьцангуй шинэ төрлийн зээл л дээ. Харин манайд хууль эрх зүйн хувьд тодорхой болгох зүйлс нэлээд байгаа. Эдийн бус хөрөнгийн барьцаатай зээл болохоор банкны хувьд эрсдэлтэй, гэхдээ үүнийг бид хоёрдугаарт тавьж байгаа. Юун түрүүнд харилцагчаа гэх маш том итгэл дээр суурилж тэдэнд санхүүгийн түлхэц өгч байгаа юм. Мөн зээл өгөөд зогсохгүй санхүүгийн зөвлөгөөг нэлээд өгөх шаардлагатай болдог. Гэхдээ энэ нь банк санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд ч бас эерэг нөлөөтэй гэж системийн нөлөө бүхий банкны хувьд үзсэн тул бид энэ зээлийг нэвтрүүлэхээр шийдсэн.

Арилжааны банкуудын зээлийн хүүнд иргэд их бухимдалтай ханддаг. Танай “Барааны тэмдэг” барьцаалах зээлийн хүү бодит боломжийг олгож чадах уу?

Зээлийн хүү маш олон хүчин зүйлээс хамаардаг ч Монгол Банкны бодлогын хүүг арилжааны банкууд суурь болгодог. Монгол Банкны бодлогын хүү дээр 2 хувийг нэмж “Барааны тэмдэг” барьцаалах зээлийн жилийн хүүг тооцож байгаа. Ийм зээлийн хүү одоогоор банкны зах зээл дээр байхгүй, бидний нэмж байгаа 2 хувь нь зардалдаа зориулагддаг гэвэл энэ зээлийн зорилго та бүхэнд ойлгогдож байгаа болов уу?

Гол нь энэ зээлээр дамжуулж бизнесээ дараагийн шатруу ахиулчихвал бидний хамтын зорилго биелж буй хэрэг юм. Харилцагчид маань томрох тусам банк улам л бэхжиж байдаг.

Тэгвэл “Барааны тэмдэг” барьцаалах зээл гарснаас хойшхи та бүгдийн тэмүүлсэн хамтын зорилго хэр биеллээ олж байна вэ?

Бид энэ оны хоёрдугаар сард бүтээгдэхүүнээ гаргасан. Бизнесүүд маань амжилттай урагшилцгааж байна, цаашид ч илүү өргөжинө гэсэн хүлээлтэй байна. Энэ зээл үндэсний үйлдвэрлэгч нарыг дэмжиж байгаа ч үүнд хамгийн их хожих нь хэрэглэгчид юм. Учир нь зээлийн хүү боломжийн түвшинд байх тусам иргэдийн гар дээр очих барааны үнэ хямд бас чанарт ч эерэгээр нөлөөлдөг.

Улаанбаатар Хотын Банк “Оюуны өмч”-г эдийн засгийн эргэлтэнд оруулахад түүчээ нь болсондоо бахдалтай байна. Манай зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд гарснаас хойш “Барааны тэмдэг”-г оюуны өмчийн газраар баталгаажуулах очер ихэссэн гэсэн. /инээв/ Энэ нь үндэсний баялаг бүтээгчид олон байгаа гэсэн үг. Өмнө нь ёс төдий байсан зүйл өнөөдөр бодит үнэ цэнийг бий болгож байна, энэ бахархмаар хэрэг биш гэжүү...

Цаашид зээлийн хэмжээ, хүүг эргэж харах боломжууд байгаа юу? Илүү хүртээмжтэй болгох тал дээр ажиллаж байна уу?

Оюуны өмч нь олон төрөлтэй. Барааны тэмдэгээс гадна Патент, Ашигтай загвар, Зохиогчийн эрх гэх мэт. Тодорхой хугацааны дараа оюуны өмчийн бусад хэлбэрүүдийг барьцаалах, эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг ээлж дараалан бүрдүүлээд явна гэдэгт итгэлтэй байна. Биднээс гадна холбогдох төрийн болон бизнесийг дэмжигч байгууллагууд үүн дээр санаа тавиад эхэлсэн нь үйл явцыг хурдасгахад нөлөөлөх байх.

Харин бид анхдагчийн хувьд зах зээлийн хамгийн бага хүүг ямар ч үед санал болгохоор зоринодоо.

Ярилцсанд баярлалаа, Амжилт хүсье.

Сурталчилгаа



ЧАКРА брэндийн үүсгэн байгуулагч: Ш.Ган-эрдэнэ

ГАНЦ ХУУДАС ЦААС Л ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ МААНЬ ХЭРЭГЛЭГЧДЭД ХҮРГЭСЭН ЮМДАА

Сүүлийн жилүүдэд импортыг орлох үндэсний үйлдвэрүүд эрчимтэй нэмэгдэж байна. ЧАКРА ч тэдгээрийн төлөөлөл яах аргагүй мөн билээ, та бизнесийнхээ талаар товч танилцуулаач?

Манайх 2017 оны 04-р сараас эхлэн ХАА-н болон байгалийн түүхий эдийг боловсруулж органик хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг ЧАКРА нэртэйгээр зах зээлд нийлүүлж эхэлсэн. Харин одоо бол ЧАКРА эмийн үйлдвэрлэлээс гадна ГАЛБИНГАА гоо сайхны бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж байна. Энэ оны 03-р сараас эхлэн Япон улсруу экспортлож эхлээд байна.

Уул уурхайн бүтээгдэхүүнүүд л зөвхөн экспортод гардаг байсан нь өөрчлөгдөж байх шиг байна. Урлаг соёлынхон маань ч гараад эхэллээ, том жишээ нь The Nu хамтлаг. ЧАКРА брэнд ч бас богино хугацаанд экспортын бүтээгдэхүүн болсон гэхээр бахархалтай сонсогдож байна. Дараагийн экспортоо хаашаа гэж харж байна вэ?

Хурдан гэж үү? /инээв/ Манайх Япон руу экспорт хийгээд хагас жил боллоо. Чацарганаас гаргаж авсан ургамлын хатаасан нунтаг омегаг хагас боловсруулсан түүхий эд хэлбэрээр хоёр төрлийг нь экспортлож байна. Өнгөрсөн өвөл Польшид туршилтын борлуулалт хийсэн нь амжилттай болсон тул саяханаас албан ёсоор экспортлож эхэлсэн. Польш дахь албан ёсны дистрибьютерээрээ дамжуулан цааш Европын холбооны улсууд руу нийлүүлэх төлөвлөгөөтэй байна. Япон, Германы олон улсад магадлан итгэмжлэгдсэн нэр хүндтэй лабораториуд манай бүтээгдэхүүнүүдийг шинжлээд амжилттай гэсэн хариу гаргасан байгаа. Өнгөрсөн 6-р сард бид Европын холбоо, Хойд Америкт хүлээнзөвшөөрөгдсөн лабораторид 25-н бүтээгдэхүүнийхээ дээжийг илгээж мөн адил утгатай хариу авсан. Ингэснээр Европ, Хойд Америк зэрэг улсууд руу экспортлох боломжтой болсон тул

бид Америкийн органик барааны сүлжээ дэлгүүрээр борлуулахаар судалж байна. Энэ мэтчилэн эцсийн бүтээгдэхүүнээ өндөр хөгжилтэй улсууд руу экспортлохоор эрчимтэй ажиллаж байнадаа. Түүхий эд нь зэрлэгээрээ болохоор гадаадын ферм болон тариалангийн түүхий эдээс шимт чанараараа хамаагүй илүү тул органик шинж чанараараа экспортын шаардлагыг хангаж, сонирхлыг нь татаж байгаа байх. Монголын айраг, сүү, саам зэрэг нь хагас зэрлэг бүтээгдэхүүнд орно. Учир нь адуу мал бэлчээрийн зэрлэг өвс ногоо идэж байгаа шүү дээ.

Монгол оронд зэрлэг жимс ногоо болон сүү цагаан идээ элбэг. Түүхий эдээ ямар шаардлага сонголтоор хаанаас авдаг вэ?

Онгон зэрлэг байгалийн түүхий эд гэдэг чухал. Жишээ нь: Ингэний сүүг Өмнөговийн, айраг саамаа Булганы Могодоос, ямааны сүүг Дундговийн, аньсыг Завханаас гэх мэт сорчилж авдаг. Байгаль эх өөрөө маш ухаалаг шүү дээ. Хүн дэлхийн хаана, ямар бүсэд амьдарч байна түүндээ таарсан тухай бүсийнхээ ургамал жимс ногоо, хоол хүнсний хэрэглэхээр заяагдсан байдаг. Монгол хүн далайн загасны өөхнөөс гаргасан омега хэрэглэхэд сэрүүднэ, оронд нь жимс ногоо, чацарганаас гаргаж авсан ОМЕГА хэрэглэхэд илүү үр дүнтэй байх жишээтэй. Айрганд хүртэл ОМЕГА агуулагддаг.

Байгалийн органик бүтээгдэхүүн тэр дундаа уламжлалт бүтээгдэхүүнээ хэрэглэх хандлага харьцангуй ихсэж байх шиг байна. Гэхдээ зэрлэг түүхий эдийг боловсруулж органик бүтээгдэхүүн гаргах технологи амаргүй байхдаа?

Тэгэлгүй яахав. Эртний Монголчууд эсгийнд сүүгээ шингээж хатаагаад, эргүүлж пургиулж хатаасан сүү гаргаж авдаг нүүдэлчний нарийн технологитой байсан. Өнөө цагт бид генийн өөрчлөлтгүй, экологийн цэвэр түүхий эд болох байгальд ургасан зэрлэг чацаргана, нэрс, аньс, долоогоно, чонын элэг жимс, хуш модны самар, цэцгийн тоос, чага мөөг, ингэний сүү, гүүний саам, монгол сармис, зөгийн бал, гоёо, хармаг, барагшуун зэрэг маш олон түүхий эдийг орчин үеийн тоног төхөөрөмж ашиглан тусгай технологиор өндөр илчлэг шимтэй хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болгодог. Үүнийг биологийн идэвхит бүтээгдэхүүн ч гэдэг. Эдгээр бүтээгдэхүүний технологийг бид өөрсдөө судалж туршиж бий болгосноороо онцлог юм. Мөн эдгээр эх орны түүхий түүхий эдүүдээ Америк, Герман зэрэг орны багахан хэмжээний түүхий эдтэй хослуулсан арьс арчилгаа гоо сайхны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг. Үүндээ Япон болон БНСУ-н технологийг ашиглаж байна даа.

ЧАКРА хүнсний нэмэлт болон ГАЛБИНГАА гоо сайхны бүтээгдэхүүнүүдийг Монголын хэрэглэгчид хэрхэн үнэлж байна вэ?

Хэрэглэгчид манай бүтээгдэхүүний үнэ болон чанарт ам сайтай байдаг. Борлуулалтын 70- 80 хувийг байнгын хэрэглэгчид бүрдүүлдэг. Хөрөнгө оруулалт хийе гэсэн санал гадныхан их тавьдаг. Харин бид хэт олон тоогоор үйлдвэрлэхээс зайлсхийж бүтээгдэхүүнээ илүү чанартай, органик байлгахыг зорьдог. Манай түүхий эдийн нөөц ч байгаль цаг уураас хамаарч хязгаарлагдмал байдаг. Монгол эрс тэс дөрвөн улиралтай. Сүүлийн 2-3 жил самрын ургац бага байгаа тул манай самартай бүтээгдэхүүн бага гарч байна. Энэ жил гэхэд нэрс бага бас үнэтэй байна. Бид байгаа түүхий эдээрээ элдэв орлуулагч, дүүргэгчгүй органик бүтээгдэхүүн хийхийг л зорьдог. Манай үйлдвэр хүчин чадлынхаа 30 хувийг л одоогоор ашиглаж байна. Цаашид бүрэн ашиглаад ирэхээр дотоодын зах зээлийн 5-10 хувийг хангах боломжтой.

ЧАКРА брэндийн бизнесийн амжилт үнэхээр том төсөөлөгдөж байна. Үндэсний үйлдвэрлэл эрхлээд явахад бахархалтай ч хэцүү зүйлс байдал л байхдаа?

Зөвхөн манайх гэлтгүй бизнесийн бүх салбарт л эргэлтийн хөрөнгө байнга дутагдаж байдаг. Гол нь эхлэл чухал. Эхэлчихсэн байхад тал талаас босгоод ирж болно. Манайх гэхэд өнгөрсөн 2-р сард ногоон цайтай ГАЛБИНГАА гоо сайхны бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах болсон юм. Сав баглаа боодлоо гадаадад захиалчихаад авах гэтэл санхүүгийн хувьд гагцхаж билээ. Тухайн үед барьцаалж болох үл хөдлөх хөрөнгө, биет зүйлсээ бүгдийг барьцаалчихсан байв. Яг тэр үед "ЧАКРА" гэх барааны тэмдгээ барьцаалж Улаанбаатар Хотын Банкнаас зээл аваад түүгээрээ бүтээгдэхүүнээ худалдаанд гаргаж билээ. Ингэж л ганц хуудас цаас

л шинэ бүтээгдэхүүнийг маань хэрэглэгчидэд хүргэсэн юмдаа. /инээв/

Барааны тэмдэг гэхээр ЧАКРА брэндээ хэлээд байна уу?

Тиймээ. Гол үнэ цэнэ бол брэнд буюу цаасан дээр буусан албан ёсны нэршилээрээ "барааны тэмдэг" юм. Ер нь үйлдвэрлэл эрхэлж байгаа компанийн хамгийн гол өмч нь брэнд түүнийг бүтээж буй технологи байдаг. Тэрнээс байшин барилга, тоног төхөөрөмж биш л дээ. Банк санхүүгийн байгууллага үл хөдлөх хөрөнгө л барьцаалж зээл өгдөг шүү дээ. Харин бид анх удаа барааны тэмдгээ барьцаалсан, тийм боломж ч анх удаа гарч ирсэн нь бидний эгзэгтэй үед туйлын хэрэг болсон.

Барьцаалсан зүйл чинь л шинэлэг өөр болохоос таны санхүүгийн асуудлыг шийдэж байгаа адилхан л зээл биш гэжүү?

Өнгөрсөн хавар санаандгүй телевизээр барааны тэмдэг барьцаалж зээл өгнө гэсэн мэдээлэл үзээд Улаанбаатар Хотын Банкны салбарт хандсан л даа. Өмнө бол оюуны өмчөө барьцаалаад зээл авах боломж байгаагүй. Гол нь хүү маш бага байсан. Сарын 1.1% хүүтэй ийм зээл гэж хаана ч байхгүй л дээ. Бод доо, жилийн хорин хэдэн хувийн хүүтэй бизнесийн зээлтэй хүн чинь зээлийн төлөлт, дэлгүүрийн түрээс, НӨАТ бусад зардал гээд л явчихаар барааны үнээ өсгөхөөс өөр аргагүй биз дээ? Харин ийм барааны тэмдгийн зээл ч юмуу, эсвэл Жайка, Азийн Хөгжлийн Банкны төслийн зээлүүд жилийн 8-12 хувийн хүүтэй байгаа нь хэрэглэгчидэд очих барааны үнэд шууд эерэгээр нөлөөлж байгаа нь маш том давуу тал юмдаа.

Ярилцсан Б.Од



Нийгэм



С.Батсайхан / ЗГМФ

Нийслэлчүүд амар тайвныг мэдэрсэн өдөр

Автомашингүй өдөр агаарын бохирдлын эсрэг нэгдэхийг уриалав

Г.Санжааханд
@sanjaakhandZGM

“Автомашингүй өдөр”-өөр төв талбай хөл хөдөлгөөн ихтэй байлаа. Нийслэлийн иргэд гэр

бүлээрээ зам чөлөөлсөн бүсээр зугаалж байгаа харагдана. Амар тайвныг мэдэрсэн нийслэлчүүд хотын төвөөр гэр бүл, найз нөхдөрөө нэг өдрийг зугаалж өнгөрөөв.

Сүхбаатарын талбай дээр “Үндэсний номын баяр”, “Цэвэр агаартай өдөр” өдөрлөг, “Япон соёлын наадам” зэрэг олон арга хэмжээ нэг дор болж байлаа. Энд ирсэн хүмүүс иргэн, аж ахуйн нэгж байгууллага дулаан, цахилгаанд холбогдох техникийн нөхцөл олгох, ногоон зээлийн

сангаас зээл авах, цахилгаан болон хийн халаагуур, сайжруулсан хатуу түлшний түгээлт борлуулалтын цэгийн мэдээлэл, орон байраа дулаалах зөвлөмж, тасалгааны цэцэг, мод үрсэлгээний талаарх зөвлөмж, мэдээллийг нэг дороос авах боломжтой байв.

Энэ жил “Цэвэр агаартай-Автомашингүй өдөр” гэдгээрээ онцлог байлаа. Өвөл болохоор асуудал болдог агаарын бохирдлын эсрэг авах боломжтой. Мөн 5000 уриалж, утаагүй зуух, халаалт,

дулаалга зэрэг аль болох агаар бохирдуулахгүй, галлагааг бууруулах зүйлсийг сонгохыг санал болгож байсан юм. Энэ үеэр “Глобал Моторс” ХХК цахилгаан машин цэнэглэгчээ олон нийтэд танилцуулж байлаа. Үүнээс гадна Нийслэлийн эрүүл мэндийн газраас хүмүүсийн даралт болон жинг үзэж, сахрын шинжилгээг үнэ төлбөргүй авлаа.

Түүнчлэн номын худалдаагаас хүссэн номоо хямдралтай үнээр авах боломжтой. Мөн 5000 дугуйчны парад, шохойн зургийн

уралдаан, спорт, урлагийн олон арга хэмжээг сонирхох боломж бүрдсэн байв.

“Автомашингүй өдөр”-ийг зохион байгуулах нь автомашины хэрэглээг хязгаарлаж, нийтийн тээвэр, унадаг дугуй зэрэг бусад тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх, явган алхалтыг дэмжих, автомашины түгжрэлээс үүдэлтэй хүн амын дундах бухимдал, цаг алдалт, дуу чимээг багасгах, агаар болон утааны бохирдлыг бууруулах зэрэг олон давуу талтай байдаг байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ЦАГ АГААР
Өнөөдөр баруун аймгуудын нутгийн баруун хэсэг, зүүн аймгуудын нутгийн зарим газраар бороо орно. Харин маргааш болон нөгөөдөр баруун, төв, зүүн аймгуудын нутгийн зарим газраар дуу цахилгаантай аадар бороо орно хэмээн ЦУОШГ-аас мэдээллээ.

» ДЭД БҮТЭЦ
“Замын цагдаагийн газрын ойролцоо баригдах гүүрэн гарц”-ын үндсэн хөдөлгөөнийг өнөөдөр нээв. Харин Их Монгол улсын гудамж руу буух баруун хойд талын “В” хэсгийн хөдөлгөөнийг энэ сарын 20-нд нээхээр төлөвлөж байна.

» УРЛАГ
Өмнөд Солонгосын “Хайрын ослын буулт” нэртэй телевизийн цуврал (драм) зураг авалтаа Монголд хийхээр болжээ. Жүжигчин Хён Бин болон Сон Ей Жин нарын гол дүрийг нь бүтээж буй романтик драмын киноны зураг авалт ирэх долоо хоногт эхлэх юм.

» ҮҮРЭГ
Төрийн байгууллагуудын гадна хаягийн 90 орчим хувь нь хууль журам, стандартад нийцээгүй, төрийн сүлд, соёмбыг буруу дүрслэх, өнгө загвар үсгийн хэмжээг баримтлаагүй зэрэг алдаатай байгаа аж. Тиймээс ирэх сарын 15-ны дотор бүх төрийн байгууллагуудад хаягаа шинэчлэх үүрэг өглөө.

» ХУДАЛДАА
“Намрын ногоон өдрүүд-2019” шинэ ногоо болон баяжуулсан хүнсний худалдаа “Мишээл экспо” төвд энэ сарын 18-24-ны өдрүүдэд болно. Тус яармаг худалдааны үеэр шинэ ургацын хүнсний ногооны болон баяжуулсан хүнс, Атар-60 жил, үндэсний хоол, мах, сүүний анхдугаар аян, органик хүнсний өдөрлөгүүд тус тус болох юм.

» НЭЭЛТ
Дэлхийн рок хөгжмийн ертөнцийг байдлан дагуулж буй Монголын “The Nu” хамтлагийн анхны “Гэрэг” цомгийн нээлт өнгөрсөн бямба гарагт АНУ-д боллоо. Тус хамтлаг арванхоёрдугаар сар хүртэл Хойд Америкт аялан тоглох юм.

» СПОРТ
Гавьяат тамирчин Э.Содномпилсэдийн Казахстан улсад зүүлсэн амжилтыг “Гинесийн ном”-д албан ёсоор бүртгэснийг Монголын паралимпийн хорооноос мэдээллээ.

» ЭРЧИМ ХҮЧ
Нийслэлийн 800 гаруй барилга, объектын халаалтыг залгаад байна. Хэрэв албан байгууллагууд халаалтаа арвадугаар сарын 1-нээс өмнө урьдчилан авахыг хүсвэл энэ талаарх өргөдлөө “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д хүргүүлэх боломжтой.

» ГЭМТ ХЭРЭГ
Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрээс эмэгтэй хүний цогцос олджээ. Тус хэргийн газарт цагдаа нар хамгаалалт аван ажиллаж байгаа бөгөөд хэрэг гарсан учир шалтгаан нь одоогоор тодорхойгүй байгаа аж.

» ЗӨРЧИЛ
Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Е Эс Би” ХХК-д үйлдвэрлэсэн “ICE AGE” нэрийн свласан месний үйлдвэрлэсэн хугацаа бичигдээгүй гэсэн иргэний гомдол НМХГ-т иржээ. Шалгалтаар зохиулалтын бус, орон сууцны нэг давхарт зөвшөөрөлгүй хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулж байсан зөрчил илэрсэн байна.

Багачуудад зориулсан үндэсний үйлдвэрлэл “Маамаа” брэнд

Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн бүлгэм цэцэрлэгийн жаалуудын хувцсыг хийж байна

О.Даваасүрэн
ЗГМ

Эцэг эхчүүд цэцэрлэгийн жаалууддаа хөдөлгөөнд садаа болохгүй, агаарын солилцоо нэвтрүүлдэг буюу хөлсийг гадагшлуулдаг дулаахан, биед эвтэйхэн хувцас өмсгөхийг эрмэлздэг. Товчхондоо цэцэрлэгийн хүүхдийн ангидаа өмсөх хувцас ээжүүдийн санаа чилээх сэдвийн нэг болдог нь үнэн. Зарим цэцэрлэг хувцсаар жигдрэх шаардлагыг тавьдаг бөгөөд дийлэнхдээ улаан шорт, цагаан подвальктай байх кодыг зааж өгөх нь ч бий. Тэгвэл Сонгинохайрхан дүүргийн зорилтот бүлгийн зарим эмэгтэйчүүд хамтран “Уран нахиа” бүлгийг байгуулж, цэцэрлэгийн хүүхдийн хувцасны үйлдвэрийн оёлын цех байгуулжээ.



“Дэлхийн зөн” олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа өнгөрсөн жилээс эхлүүлсэн тус бүлгийнхэн эхний ээлжинд том үйлдвэрүүдээс мас-сын ажил авч хийдэг байсан аж. Харин энэ намраас өөрсдийн нэрийн бүтээгдэхүүн гаргаж эхэлсэн нь “Маамаа” брэнд.

“Уран нахиа” бүлгийн ахлагч Б.Энхжаргал “Манай бүлэг нь зорилтот бүлгийн ээжүүдийг ажлын байраар хангаж байдгаараа онцлог. Энэ намраас СХД-ийн Засаг даргын санаачлагаар “Маамаа” брэндийг үүсгэж, хүүхдийн биед харшил өгөхгүй, хөвөн даавуугаар хослол буюу шорт, подвалькыг нь хийж

сүлжээгээр хийдэг аж. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газар, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, эцэг эхчүүд дэмжин ажиллаж байгаа аж. Одоогоор гурван цэцэрлэгтэй хамтын ажиллагаагаа эхлүүлээд байгаа бөгөөд өнгөрсөн баасан гарагт СХД-ийн 260 дугаар цэцэрлэгт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн юм.

Тус цэцэрлэгийн эрхлэгч Б.Одсүрэн “Цэцэрлэгийн хүүхдүүд биеийн тамирын хувцсаар жигдрэх шаардлагатай байдаг. Өмнөх жилүүдэд голдуу л урд хөршөөс оруулж ирсэн хослолыг сонгож өмсдөг байсан бол энэ жилээс эх орондоо үйлдвэрлэсэн, цэвэр даавуун хувцсаар ижилсэх боломж бүрдэж байна. Энэ нь үндэсний үйлдвэрээ дэмжиж байгаа төдийгүй эцэг эхчүүдэд ч чанартай бүтээгдэхүүнийг боломжийн үнээр санал болгож байгаа юм. Уг хувцас нь хүүхдийн биед эвтэйхэн, өнгө үзэмж сайтай учир бид хамтарч ажиллахаар болсон” хэмээв.

Цэцэрлэгүүдтэй хамтарч ажиллахад дүүрэг болон хороодын Засаг даргын Тамгын газар дэмждэг байна. Энэ талаар СХД-ийн ЗДТГ-ын Нийгмийн оёдолчдыг нь мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.

Цэцэрлэгийн хүүхдийн нэг хослолыг 13,500 төгрөгөөр борлуулах бөгөөд борлуулалт, сургалчлагаагаа олон нийтийн

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ Нисэх, Яармагт 30 гаруй км авто замын трасс гаргана

Нисэх, Яармаг орчинд барилгажилт, газар олголт ихсэж байгаатай холбоотойгоор орц, гарцын асуудлыг шийдэх, авто замын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж гаргах үүргийг Нийслэлийн Засаг дарга өгсөн. “Холбогдох тогтоолууд батлагдсаны дагуу Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж авто замын гол трассуудыг эхний ээлжид гаргана. Өөрөөр хэлбэл, 13 км зургаан эгнээтэй

нэгдүгээр зэргийн гол зам гаргах, туслах гудамж замыг гаргах гэх мэт нийт 30 гаруй км авто замын трасс гаргахаар болоод байна. Авто замын трасс өртөж буй 116 аж ахуйн нэгжийн газар байгаа тул холбогдох газруудтай нь зөвшилцөж газар чөлөөлөлтийн ажлыг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай болсон” хэмээн Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн төлөвлөгөөний газрын Хот төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Түмэн-Од ярих. [ЗГМ]

Өнөөдрөөс “Сайн карт”-ыг хорооноос авах боломжтой

“Таван толгой түлш” компанийн үйлдвэрлэсэн сайжруулсан түлшийг дүүрэг хороодын түлшний цэгүүдэд хүргэх ажлыг эрчимжүүлж эхэлсэн байна. Энэ хүрээнд тээвэрлэлтийн компанийн өмнө тулгараад байсан сайжруулсан түлш ачиж, буулгахад шаардлагатай 200 орчим ажилтны асуудлыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Хот тохиожилт, дүүргүүдийн ТҮК-ийн ажилчдаас татан төвлөрүүлэхээр болжээ. Гэр хорооллын иргэдэд сайжруулсан түлш авах хяналтын

“Сайн карт”-ыг үнэ төлбөргүй хүргэнэ. Тухайн картын хувьд төлбөрийн хэрэгсэл биш, нэг өрх өвлийн турш хэрэглэх гурван тоннын хэрэглээг хянах цахим хяналтын хэрэгсэл аж. Иргэд тус картыг өнөөдрөөс эхлэн өөрийн харьяа хорооноос авч болох бөгөөд сайжруулсан түлш худалдан авах бүртгээ тухайн цэг дээрх худалдагчид байх төхөөрөмжид давхар уншуулан худалдан авсан түлшээ “Сайн карт” дахь гурван тоннын квотоосоо хасуулах байдлаар хэрэглэх юм. [ЗГМ]

Бүх нийтийн цэвэрлэгээнд хяналт тавин ажиллажээ

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 130 улсын байцаагч хороодыг хариуцан бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт тавьж ажиллажээ. Тус ажлын хүрээнд хог хаягдал, орчны цэвэрлэгээг хийх тухай 2958 мэдэгдлийг урьдчилан хүргүүлж, 12278 иргэн, аж ахуйн

нэгж, байгууллагыг хамруулж, хог хаягдал, гадна орчныг угааж цэвэрлүүлсэн байна. Цэвэрлэгээнд хамрагдаагүй 199 иргэн, аж ахуйн нэгжид шаардлага тавин цэвэрлэгээнд хамруулж, хангалтгүй оролцсон дөрвөн аж ахуйн нэгжид улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавьжээ. [ЗГМ]

ZGM DAILY

The budget surplus increases by 34 percent

Total equilibrated revenue of the General government budget reached MNT 6.9 trillion.

Mongolia signs financing agreement with World Bank

The funding is being granted within the Extended Fund Facility Program.

Minister of Foreign Affairs meets Ambassador of Cuba to Mongolia

The sides discussed issues concerning bilateral relations of Mongolia and Cuba.

Top 20 index increases 1.28 percent, to 19,477.47 points

Market cap stands at MNT 2,48 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS


Parliament Speaker Zandanshatar Gombojav meets UN Resident Coordinator and UNDP Resident Representative in Mongolia Beate Trankmann.

Minister of Foreign Affairs of Mongolia Tsogtbaatar Damdin receives Ambassador of the Republic of Cuba to Mongolia Raúl Delgado Concepción on September 13. The meeting discussed a range of issues concerning bilateral relations of Mongolia and Cuba and multifaceted cooperation.

ECONOMY

The 32nd ATPF Asian Trade Promotion Forum's CEO Meeting takes place in Ulaanbaatar under the theme "The Role of TPOs in Supporting SMEs to internationalize and connect to value chain" on September 12-13.

Top 20 index increases 1.28 percent, to 19,477.47 points. MSE A index rises 0.25 percent, to 8,987.6 points. MSE B index up 0.05 percent, to 7,614.84 points. Market cap stands at MNT 2,48 trillion.



SOCIETY

The Mongolian and Chinese models jointly presented well-designed costumes for the opening ceremony of the Silk Road International Fashion Week Overseas Exhibition Tour. This event is a part of activities to celebrate the 70th anniversary of the establishment of diplomatic relations between Mongolia and China.

Budget surplus reaches MNT 549.7 billion as exports stabilize

General government budget amounted to MNT 6.9 trillion

Aminaa.U
ZGM

In the first eight months of 2019, total equilibrated revenue and grants of the General government budget amounted to MNT 6.9 trillion and total expenditure and net lending amounted to MNT 6.3 trillion, resulting a surplus of MNT 549.7 billion in the equilibrated balance, according to the National Statistics Office (NSO). The budget surplus increased by 34 percent from the same period of the previous year, as a result of stable mineral product prices and exports.

The budget deficit reached MNT 1.8 trillion in the first eight months of 2016, due to the economic crisis. Tax revenues, generate more than 80 percent of the budget revenue increased by 21.5 percent from the previous year, reflecting the budget surplus. However, total expenditure and net lending of the General government budget increased by MNT 920.3 billion or 17 percent year-over-year. This increase was mainly due to MNT 532.1 billion



Batsaikhan.S / ZGM©

increase in current expenditure and MNT 460.4 billion or 69 percent increase in capital expenditure.

In the meantime, NSO also announced the new debt statistic. The gross external debt of Mongolia increased by 7.3 percent to USD 29.7 billion in the first half of the year. The general government debt

increased by MNT 1.6 trillion or 7.6 percent and reached MNT 22.7 trillion. year. In general government debt, foreign debt accounts for 85 percent or MNT 19.3 trillion.

The government will pay international bonds from 2021. In other words, Mongolia will pay a total of USD 2.9 billion for the


next four years, which is the main challenge for the country.

Furthermore, the total foreign trade turnover increased by 11.9 percent in August 2019, mainly due to the 15 percent increase in exports. The rise of coal and unprocessed or semi-processed gold exports has been the key driver as well.


Foreign trade surplus increased by USD 426.6 million to USD 1.3 billion from the same period of the previous year. Imports indicate that mining-related products are the main reason for foreign trade surplus. For example, imports of diesel fuel, transportation, and parts of vehicles increased by USD 176 million. [ZGM]

STOCK MARKET


Hai Bi Oil JSC
(one month to date)



SUU JSC
(one month to date)




Talkh Chikher JSC
(one month to date)



FINANCE

Mongolia signs financing agreement of USD 100 million



Minister of Finance Khurelbaatar Chimed and World Bank's Country Manager for Mongolia Andrei Mikhnev on Friday signed a financing agreement of USD 100 million for the second Economic Management Support Operation.

The funding is being granted within the Extended Fund Facility (EFF) Program running by the Government of Mongolia in partnership with the International Monetary Fund (IMF). The first funding of the program or USD 120 million was granted in December 2017. Accordingly, the World Bank's International Development Association and the International Bank for Reconstruction and Development are jointly providing USD 100 million for the second phase.

The funding will be spent on reducing expense of public

investment projects, increasing their efficiencies, increasing housing access in a way of improving apartment mortgage program, strengthening social protection system, upgrading business environment and ensuring implementation of the law on Animal Health.

"Mongolia's economic growth was at 7.2 percent in 2018 and 7.3 percent as of the second quarter of 2019. Mongolia's credit rating has been upgrading. The World Bank Group Board of Directors convened two months ago, where they resolved to grant funding of USD 100 million to Mongolia. The Parliament ratified draft law on the issuance of funding on September 12. This financing will aim to support budget, not to implement projects and programs," said the Minister of Finance Khurelbaatar Chimed. [ZGM]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

Эдийн засаг, уул уурхайн чансаатай мэдээллээр олонд танигдсан "Засгийн газрын мэдээ" сонин өдөр тутам шинэ дугаараа уншигчдадаа өргөн барьдаг.

Манай сонины эдийн засгийн шинжээчид, олон улсын экспертүүд дэлхийн болон Монголын уул уурхайн салбарын төлөв, судалгаа, шинэчлэл болон улс төрийн бодлого энэ салбарт хэрхэн өрнөж буйг цаг үеийн нарийн мэдрэмжтэй мэдээлсээр ирсэн.

zgm.mn ZGMDaily
ZGMmn zgm.mn
70103131 99903581 99907843



Өдрийн хэмнэл



TARGARYEN FIRE AND BLOOD

ОНЦЛОХ ҮЗВЭР

НВО суваг Таргариен удмын тухай цуврал хийнэ

Дейнерис Таргариены шүтэн бишрэгчид хайртай баатрынхаа гарал үүсэл болон түүний гэр бүлийн хүчирхэг луунуудыг дахин харах магадлалтай боллоо. Учир нь НВО суваг "The Game of Thrones" олон ангит киноны приквел болох Таргариен удмын тухай цуврал хийхээр ажиллаж байгааг The Hollywood Reporter мэдээллээ.

Энэхүү цувралд Жорж Р.Р. Мартины "Гал мөсний дуун" зохиолын хамгийн хүчирхэг гэр бүлүүдийн нэг болох Таргариен удмынхны тухай илүү дэлгэрэнгүй үзүүлнэ хэмээн эх сурвалж өгүүлсэн аж. Шинэ төсөлд "Game of Thrones" цувралаас 300 жилийн өмнөх түүхийг өгүүлэх бөгөөд үүнд Таргариен удмын сэргэн мандалт болон уналтыг харуулах юм. Цувралыг Жорж Р.Р. Мартины "Fire and Blood" номоос сэдэвлэж байгаа аж. Мөн алдарт зохиолч тус төсөл дээр кино зохиолч, продюсер Райан Кондалтай хамтран ажиллах болно. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР



- 09.00 Технологийн ертөнцөөр
10.30 Хөгжлийн замаар "Соёлын аялал жуулчлал"
14.30 Робокоп-2019
16.00 "Улаан дарс" Оросын уран сайхны кино
17.00 Ардчиллын өдөрт "Нийгмийн хэлэлцүүлэг"
21.10 "Алсын хараа 25" Монгол Улсын дээд боловсрол дэлхийд ...
Bloomberg TV Mongolia
07.00 "Сая долларын суутан" нэвтрүүлэг
09.00 "Бизнесийн хэмнэл" хөтөлбөр
11.30 "Боломжгүй өөрчлөх төсөл" нэвтрүүлэг
14.00 "Америкийг бүтээсэн эрхмүүд" нэвтрүүлэг
17.00 "Bloomberg Technology"
20.00 "Cars and Coffee" нэвтрүүлэг
22.00 "Суутнуудын намтар" нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

- 07.45 "Консуни" хүүхэдэйн кино 19-20-р анги
12.05 "Аугаа зуун" ОАК 2-р бүлэг 20-р анги
14.05 "Хайр гэж" тоглолт /МУГЖ Ж.Алтанцэцэг/ 1-р хэсэг
15.30 Хятад хэлний "Алсын зайн сургалт" дунд шат /4-р хичээл/
20.55 "Дэлхийгээр Аялагчид" нэвтрүүлэг
00.40 "Кино миний амьдрал" нэвтрүүлэг



- 07.00 Өнөө өглөө
12.00 Хөтөч мэдээллийн хөтөлбөр
16.00 "Sky шилтгээн" COAK 6-р анги
17.10 "Ан амьтдын ертөнцөөр" /season-8/ 13-р хэсэг
18.30 Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
21.00 Нүүдэл Шийдэл
01.00 Үдшийн мэдээ

ЗУРХАЙ



Билгийн тооллын 17
Намрын илүү тэргүүн сарын гурван хөх мэнгээтэй улаан луу өдөр
Үс засуулбал: Өнгө зүс доройтно Наран ургах, шингэх: 06.27-19.01

Барилдлага: Рашаан
Шүтэн барилдлага: Сэрэхүй
Суудал: Гал

Аргын тооллын есдүгээр сарын 16, Сумъяа гараг. Билгийн тооллын 17, Дэлгэрүүлэгч одтой, улаан луу өдөр.

Өдрийн наран 06.27 цагт мандан, 19.01 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, лус тахиx, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



"Надтай үлдээч" уянгын драм
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.09.15-20
Тасалбарын үнэ: ₮10-25 мянга



Галзуу хот шоу драм
Хаана: МҮЭСТО
Хэзээ: 2019.09.15-19-нд
Тасалбарын үнэ: ₮15, 18 мянган



Чамдаа яараад байна тоглолт
Хэзээ: 2019.09.27-нд
Хаана: Улаанбаатар палас
Тасалбарын үнэ: ₮20 мянга

ЦАГ АГААР

УЛААНБААТАР





ФОТО АГШИН



Сэлэнгэ аймгийн Мандал сумын малчин өглөөний саалиа тушааж буй нь. Ургах нартай уралдан хөдөлж сүүгээ цуглуулах жолооч юмкосоо дүүргэсэн даруй хотын зүг хөдөлнө.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ





- БОСООГООР: 1. Олон улсын нэгжийн систем
2. Хөгжмийн нот
3. Хөгжмийн нот
4. Иргэний болон үйлдвэрлэлийн барилга байгууламжид хэрэглэгддэг модулийн төхөөрөмжүүд (автомат таслуур)
6. Жижиг биетэй, хүдэр шиг хөлтэй, гур шиг эвэртэй гөрөөс
7. Алдарт Н.Михалковын Монголын тухай хийсэн кино, олон улсын наадмуудын олон тэргүүн шагналт бүтээл
8. "Буяныг гаргахгүй, бузрыг оруулахгүй" гэж тангарагтай байгууллага
9. "Цогт Тайж" киноны нэгэн дүр
10. Монгол Улсад ачаа тээврийн үүрэг гүйцэтгэж буй Японы автомашин
11. Түвдийн нийслэл
13. Тархинд хамгийн сайн хоол хүнс гэгддэг жимс
14. Гэрийн мод

- ХӨНДЛӨНГӨӨР: 1. Намар ногооноороо байгаа өвс ургамал, өвсний шим
3. Бузар, цөв шүглэсэн муу юм
5. У.Шекспирийн "Оттелло" жүжгийн дүр
11. Афганистанаас гаралтай хүнсний ногоо
12. Бүлээн
15. Жанжин Сүхбаатарын төрсөн газар
ТАШУУГААР: 1. Шашны дагаж мөрдөх ёс журам, сахилга
4. Манай дэлхийн хамгийн том гүрвэл



Өмнөх дугаарын хариу /09.13

ЗГМ: СҮДОКУ



Ангилал: нэрвэл/хөнгөл



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

Table with 2 columns: Train route and departure times. Rows include UB-Moskva, EREN-UB, UB-BEEJIN, etc.



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Table with 2 columns: Flight route and departure times. Rows include UB-BEEJIN, BEEJIN-UB, UB-BERLIN, etc.

ЭДИЙН ЗАСАГ

Цэнэг дуусдаггүй машин бүтээх хайгуул

Prius-ын туршилтын загвар цэнэггүйгээр 56 километр туулж чадлаа.

> 10

АНУ-ын эмийн хангамжид нэвчиж буй хавдар үүсгэгч

Патентгүй үйлдвэрлэдэг эмийн найрлага дахь бохир хольц дэлхий нийтийг түгшүүлэх боллоо.

> 10

Тамхинаас аюулгүй гэгдэж байсан вэйпийн бүрхэг хувь заяа

Цахим тамхи нь залуу үеийнхнийг никотины хамааралтай болгох эрсдэл дэлхий даяар ихэслээ.

> 10



Компанийн мэдээлснээр Абкайк болон Хуайс үйлдвэрүүдэд халдлагын улмаас гарсан түймрийг унтраасан бөгөөд хүний амь хохироогүй байна.

Саудын нефтийн үйлдвэрүүд рүү дайрсанд Ираныг буруутгав

Иемен дэх Ираны дэмжлэгтэй хути босогчид Саудын нефтийн үйлдвэрлэлийн гарцыг тал хувиар бууруулсан халдлагын хариуцлагыг өөртөө авсан. Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч Жудд Дир “Эрчим хүчний чухал байгууламж руу хийсэн халдлагыг АНУ эрс буруушааж байна. Манай засаг захиргаа дэлхийн нефтийн зах зээлийг тогтвортой барихын тулд хяналт тавьж, ажиглана” хэмээн бичжээ. Трампыг тууштай дэмжигч, БНН-ын сенатч Линдси Грэм Иран дахь байнуудад цохилт өгөхийг уриалсан.

Агатсо-гийн үйлдвэр рүү хэд хэдэн дроноор довтолсон явдал тус компанийн олборлолтыг өдөрт 5.7 сая баррелиар буурууллаа гэж мэдээлжээ.

Иран өдөөн хатгалгаа үргэлжлүүлж, уран баяжуулахаа зогсоохгүй бол АНУ тэдний нефть боловсруулах үйлдвэрүүдэд цохилт өгөх асуудлыг хэлэлцэх цаг нь болсон. Үйлдвэрийг довтлох гэх мэт илүү бодитой үр дагавар үзэгдэхээс наана Иран буруу үйл ажиллагаагаа зогсоохгүй” хэмээн бичжээ. АНУ-аас Саудын Арабт суугаа Элчин сайд Жон Абизейд “Чухал байгууламж руу довтолж, энгийн иргэдийг аюулд оруулсныг хүлээн зөвшөөрөх ёсгүй. Эрт орой хэзээ нэгэн цагт гэм зэмгүй иргэд хохирох болно” гэж анхаарууллаа.

Саудын Араб даваа гарагаас хэтрүүлэлгүй нефтийн нийлүүлэлтийг хэвийн хэмжээнд хүргэнэ гэж албаныхан ярьсан байна. Түүнчлэн дэлхийн зах зээлд тасалдал үүсгэхгүйн тулд тус улс гадаадын хэрэглэгчдэд өөрийн нөөцөөс нийлүүлэх санаачилга гарчээ. Арабын улсуудын холбоо Саудын үйлдвэрүүд рүү дайрсан хэргийн талаар мөрдөн байцаалт эхлүүлсэн мэдэгдэв. Холбооны төлөөлөгч Турки аль Малики “Энэхүү алан хядах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлсэн этгээдүүдийг тодорхойлохоор ажиллаж байна” гэжээ. 2015 оноос Саудын Арабын онгоцууд Йемений нутаг дах хуситын байрлалыг бөмбөгдөх болсон учир босогчид хариу дайралт хийж эхэлсэн юм.

Малайз улс үүл буудаж түймэртэй тэмцэхээр төлөвлөжээ

Карлис Сална Зүүн Өмнөд Азийн бүс нутагт 4000 орчим цэгт гал түймэр шатаж утаа тортогт бүрхэгдээд байна. Малайзын Засгийн газрын шадар сайд Минарах Мажилис Star сонинд өгсөн ярилцлагадаа улс орныг нөмөрсөн түймрийн аюулыг хөндөж, Селангар муж болон бусад газарт үүл буудах замаар гал түймэртэй тэмцэхээр төлөвлөж буйгаа мэдэгдэв. Түүнчлэн Индонезийн засаг захиргаа Суматра ба Калимантан арлуудад гарсан түймрийн хэрэгт далдуу модны тос үйлдвэрлэгч дөрвөн компанийг шалгаж байгаа аж. Түймрийн улмаас тус улсад 42 үл хөдлөх хөрөнгийг битүүмжилж, иргэдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авчээ. Энд гарсан түймрийн утаанаас болж Сингапурт агаарын бохирдол аюултай түвшинд хүрснийг албаныхан анхааруулсан юм.

Филиппиний эмэгтэй нисэгчид Азийн аялал жуулчлалд тусална



Клер Жиао Филиппиний хамгийн том нисэхийн сургууль эмэгтэйчүүдийг элсүүлж, Азид нисэхийн мэргэжилтэн дутагдалтай байгааг нөхөх төлөвлөгөө боловсруулжээ. Пампага муж дахь Alpha группийн нисэхийн сургуулийн 550 оюутны тавны нэг нь эмэгтэй сонсогч болсон байна. Гэтэл дэлхий даяар нийт нисэгчдийн дөнгөж гурван хувь нь эмэгтэй байгааг сургуулийн захирал Бхану Чаудхри ярилаа. Тэрбээр их дээд сургуулиуд дээр элсэлтийн хөтөлбөр хэрэгжүүлж, эмэгтэйчүүдэд нисэгч болох үүд хаалгыг нээж буйгаа онцлов. Boeing компанийн тооцоогоор Азид 2038 он гэхэд нэмэлтээр 266 мянган нисэгч шаардлагатай байгаа нь дэлхийн нийт эрэлтийн гуравны нэгийг бүрдүүлэх юм. Аялал жуулчлал асар хурдацтай өсөж байгаа боловч агаарын компаниудын боловсон хүчний хомсдолын улмаас зарим компани нислэгээ цөөрүүлж эхэлсэн. Филиппинд Англи хэлийг өргөн хэрэглэдэг учир олон улсын шугамд ажиллах нисэгчдийг бэлтгэх давуу тал болж байна.

Сөүл Японыг найдвартай түншийн жагсаалтаас хасаж болзошгүй



Bloomberg News Өмнөд Солонгосын Засгийн газар итгэлтэй экспортын улсуудыг багтаадаг цагаан жагсаалтаас Японыг хасаж шийдвэрээ энэ долоо хоногт зарлах байх гэж Yonhap агентлаг мэдээлсэн байна. Хэрэв уг арга хэмжээ хэрэгжиж эхэлбэл АНУ тэргүүтэй 29 гишүүн орныг багтаадаг экспортын хялбаршуулсан дэглэмээс Япон улсыг хасаж, экспортын хатуу хяналтын нөхцөлд шилжих болно гэж Өмнөд Солонгосын Худалдааны яамны эх сурвалжийг эш татан мэдээлжээ. Японыг оруулах шинэ бүлэгт экспортыг хяналтын дэглэмтэй орнууд бөгөөд тэдгээрийг хэвийн дүрэм журмыг зөрчдөг буюу зохисгүй бодлого баримталдаг гэж үздэг аж. Өнгөрсөн сард Японы Засгийн газар Өмнөд Солонгосыг давуу эрхтэй худалдааны түншийн жагсаалтаас хассаны хариуд Сөүл ийм алхам хийж байгаа бололтой. 1910-1945 оны хооронд Японы эзэнт гүрэн Солонгосын хойгийг колоничилж байснаас үүдсэн маргааныг бүрэн зохицуулж чадахгүй байсаар асуудал хурцадсан тул Токио, Сөүлийн харилцаа сүүлийн хэдэн арван жилд үзэгдээгүйгээр муудаад байна. Өнгөрсөн жилд Японд Өмнөд Солонгос Дэлхийн худалдааны байгууллагад хандаж, Японы импортын хязгаарлалтын талаар гомдол мэдүүлсэн. Худалдааны яамны мэдэгдэлд Японд мөн мэдэгдэл хүргүүлж, өөрчлөлтийн үндэслэлийг тайлбарласан байна. Сөүл түүнчлэн Токио хүсвэл ямар ч үед, хаана ч хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа мэдэгджээ.

Авлигачин тэрбумтнуудаас юу дор вэ, социализм уу

Шили Рен (Bloomberg-ийн үзэл бодол)

Засгийн газрыг хахуульдаг тэрбумтнуудаас юу дор вэ? гэж асуувал “Ганнамын зүүнийхэн” гэж хариулж магадгүй. Чонбукын их сургуулийн профессор Кан Жунман сүүлийн номдоо энэ сэдвийг хөндөж, цалингийн доод хэмжээг нэмэх, улсын салбарт ажлын байр бий болгох гэх мэт социалист үзэл санааг дэмждэг Өмнөд Солонгосын баячуудын тухай өгүүлжээ. Иймэрхүү технократууд саяхан халуун усанд шалзуулсны нэг нь Ерөнхийлөгч Мун Жа Иний томилсон Хууль зүйн сайд өөрөө авлигын хэрэгт холбогдсон явдал. Ноён Мун өмнөх Ерөнхийлөгч болон томоохон корпорациуд холбогдсон авлигын дуулиан дээр сонгогдсон. Тэрбээр Өмнөд Солонгосын хамгийн зүүний үзэлтэй Ерөнхийлөгч агаад амласны дагуу чазбэл хэмээх аварга корпорациудыг шинэчлэх зарим алхам хийлээ. Samsung, Hyundai мэтийн компаниудад бүтцийн өөрчлөлт хийгдсэний үр дүнд хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг хорин жилийн дээд түвшинд ирэв. Гэсэн хэдий ч чабалуудыг үл таашаах хөрөнгө оруулагчдын санаа бодол сайжирсангүй. KOSPI индекс арван жилийн доод цэг рүү унаж, өөрөөр хэлбэл санал болгосон үнэ дээр тогтов. Түүнчлэн богино арилжааг хориглох тухай ярианы улмаас Сөүл асар их мөнгө алдлаа. Үүнд Хятад, АНУ-ын худалдааны дайныг буруутгах хүсэл төрж магадгүй. Өмнөд Солонгосын эдийн засаг хагас дамжуулагч мэтийн



циклээс хамааралтай экспортод суурилдаг. Гэхдээ л Samsung мэтийн үйлдвэрлэгчдийн хувьцаа энэ жил онц өөрчлөгдсөнгүй. Арилжаачдын сэтгэлийг зовоож байгаа зүйл нь ноён Мун өөрөө юм. Тэрбээр олон нийтэд нэр хүндтэй боловч компаниудын удирдлага түүний бодлогод үл итгэж байна. Учир нь улс орны бизнесийн төлөвийг хэмждэг капиталын хөрөнгө оруулалтын өсөлт түүнийг албан тушаалд орсон 2017 оноос буюу худалдааны дайн эхлэхээс өмнө буурч эхэлсэн явдал юм. Сүүлийн хоёр жилд цалингийн доод хэмжээг хоёр оронтой тоогоор

өгсгөсөн нь жижиг бизнест хүндээр тусаж, ажиллах хүчний зардлыг нэмлээ. Үүний сацуу үл хөдлөхийн зах зээлийг халалтаас сэргийлэх захиргааны арга хэмжээ нь шинэ барилгыг саатуулж, барилгын компаниудын хувьцааг унагав. Яаж бүр муутгах вэ гэсэн шиг Японтой үүссэн маргааныг ноён Мун буруу зохицуулж буй нь илт мэдэгдэж, АНУ-тай байгуулсан тагнуулын мэдээ солилцох гэрээг саатуулж магадгүй боллоо. Дэлхийн II дайны дараах улс төрийн холбоо эдийн засгийн харилцан хамаарал болж, хамтын хөгжил цэцэглэл, экспортод

Ноён Мун өмнөх Ерөнхийлөгч болон томоохон корпорациуд холбогдсон авлигын дуулиан дээр сонгогдсон.

чиглэсэн шинэ зах зээл бий болгосон. Гэвч одоо АНУ-тай ойр байх хэрэгцээ суларч, тодорхойгүй бүс рүү орж байна. Ерөнхийлөгч Трамп Умардаас хамгаалах зардалд Сөүл илүү ихийг гаргахыг шаардсан. Вашингтон, Бээжингийн хооронд явагдаж буй технологийн давуу байдлын төлөөх тэмцэлд Өмнөд Солонгос үл оролцогч хэвээр үлдэхэд нэн төвөгтэй. Хятад улс Өмнөд Солонгосын ДНБ-ий 44 хувьтай тэнцэх хэмжээний барааг импортоор авдаг. Гэтэл АНУ Хятад руу чип экспортлохыг хориглосон нь холбоотон улсад хүндээр тусав. Хагас дамжуулагч Өмнөд Солонгосоос Хятад руу хийдэг экспортын гуравны нэгийг эзэлж байгаа. Харамсалтай нь тус улс дэлхийн худалдааны нэг төв агаад чабалууд KOSPI индексийн зах зээлийн үнэлгээний талаас илүүг бүрдүүлдэг. Тэрбумтнууд хөрөнгөө хаяад зугтахгүй нь лавтай тул хувьцаагаа буцаан худалдан авах замаар үнийг дэмжиж буй. Дээр нь Ерөнхийлөгч Муны захиргаа зах зээлийн эрдэлийн босгыг дээшлүүлж байгаа учир Солонгосын давуу талыг хязгаарлаж болзошгүй. Хувьцааны зах зээл капитализм болон чөлөөт бизнест суурилдаг хуультай. Чабалуудын улстөрчидтэй тогтоосон бараан холбоо сүлбээ, хувьцааны сүлжилсэн эзэмшил хөрөнгө оруулагчдыг үргээж байсан. Гэтэл одоо дээр нь социалист Засгийн газар чөлөөт бизнесийг хязгаарлах үзэл санаа байдлыг бүр ч дордуулах төлөвтэй боллоо.

Эдийн засаг

Же Ма

Мөнгөөр худалдаад авч болох хамгийн сайн нарны панель, супер үр ашигтай ажилладаг зай хураагуур, зуу гаруй жилийн түүхт авто үйлдвэрлэлийн ноу-хауг нэгтгэж орхивол онолын хувьд машин мөнх давхиад байж чадна.

Тээврийн салбарт хувьсгалт эргэлт авчирч болзошгүй Prius-ыг туршиж буй Toyota Motor Corp, Sharp Corp, NEDO (New Energy and Industrial Technology Development Organization) буюу Шинэ Эрчим Хүч, Үйлдвэрлэлийн Технологи Хөгжүүлэх Байгууллагын хамтын төслийн хөдөлгөгч хүч нь чухамдаа энэхүү зоригтой санаа юм.

Prius-ийн туршилтын загвар цэнэггүйгээр 56 километр туулж чадлаа



Цэнэг дуусдаггүй машин бүтээх хайгуул

“Урт зай туулж чаддаггүй ч цэнэглэх төхөөрөмжөөс хамааралгүй нь нарны машины гол давуу тал” хэмээн Toyota-гийн төслийн менежер Кожико Макино тайлбарлав.

Бүрэн цахилгаан хөдөлгүүрт машин борлуулалтаар бензин хөдөлгүүрт машиныг гүйцлээ ч аанай л цэнэглэх төхөөрөмжид залгах шаардлагатай учраас дэлхий даяар цэнэглэх станцын сүлжээ байгуулахаас аргагүй. Тэгвэл дэлхий даяар үнэ төлбөргүй гэрэлтдэг нарны эрчим хүчийг их чадлын зай хураагууртай хослуулчихвал шөнөдөө автомашинаа цэнэглээд байж болно. Ийм нарны машин бүтээж чадах аваас plug-in

гибрид, устөрөгчийн шатахууны элементийн автомашин зэрэг өнөөгийн шинэ эрчим хүчний бүх технологийг ардаа орхих юм. Нарны автомашиныг ийм түвшинд хөгжүүлэх гэвэл хийх ажил их. “Ирэх арван жилээс хаа

сайгүй хэрэглээ болох технологи лав биш. Их хугацаа орно” хэмээн консалтингийн Capogama фирмийн автын аналитист Такешо Мияо үзэж байна.

Toyota Motor Corp, Hyundai Motor Co дээвэртэй нарны панель

бүхий автомашин аль хэдийн худалдаанд гаргасан. Гэхдээ чадал нь дэндүү бага, бүхээгийн дуу хөгжим тоглуулагч системийг ажиллуулж дөнгөх төдий.

Prius-ын plug-in хувилбарт нарны панелийн нэмэлт сонголт

байдаг ч зөвхөн машин зогсоотой үед л зай хураагуураа цэнэглэдэг. Нарны үүсгүүрээс үүссэн цэнэгээр ердөө зургаан километр туулах бололцоотойг NEDO-гийн нарны эрчим хүчний системийн хэлтсийн захирал Мицүхиро

Ямазаки тайлбарлав.

Нарны эрчим хүчээр ажиллах учиртай шинэ Prius-ийг долдугаар сараас хойш туршиж буй Toyota компани өөрөө ч цэнэглэх төхөөрөмжид залгадаггүй машин бүтээгэл хол байгааг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ Тойота хотод төвтэй тус компани судалгаа хөгжүүлэлтийн ажил өөр бусад хэлбэрээр үр шимээ өгнө хэмээн үзэж байгаа юм.

Үр дүн захаасаа гарч эхэлсэн нь Sharp-тай холбоотой. Өнөөгийн зах зээл дэх панелиуд нарны гэрлийг эрчим хүч болгон хувиргах ашигт үйлийн коэффициент (АУК) дөнгөж 20 орчим хувьтай. Харин Sharp компанийн туршилтын шатандаа яваа нарны панелийнх 34 хувь.

Toyota, Sharp, NEDO-гийн нарны тэжээлийн элемент ердөө 0.03 миллиметрийн зузаантай тул машины дээвэр, урд хамар, арын хаалга гээд хүнхэр, гүдгэр гадаргад хүртэл суурилуулж болно. Цахилгаан тэжээлийн систем нь машиныг давхиж явах үед ч цэнэглэнэ.

Машин долоо хоногтоо дөрвөн өдөр гадуур явдаг, өдөртөө 50 километрээс илүүгүй зай туулдаг тохиолдолд цахилгаан түгээх системд залгаж цэнэглэх шаардлагагүй хэмээн NEDO-гийн Ямазаки тайлбарлав.

Toyota-гийн нарны зай хураагууртай машин нь Японы тэргүүлэх авто үйлдвэрлэгчээс ирээдүйн тээврийн хэрэгсэл бүтээж хөгжүүлэх олон ажлын ердөө нэг нь. Технологи, бизнесийн шинэ загвар 2.23 их наяд ам.долларын авто үйлдвэрлэлийн ирээдүйг бүрхэг болгосоор байгаатай уялдан Volkswagen AG зэрэг тэргүүлэх үйлдвэрлэгчид цахилгаан болон ус төрөгчийн элементээр ажилладаг машин бүтээх ажилд олон тэрбум ам.долларын хөрөнгө оруулцаж байна.



Цахим тамхи нь залуу үеийнхнийг никотины хамааралтай болгох эрсдэл дэлхий даяар ихэслээ.

Тамхинаас аюулгүй гэгдэж байсан вэйпийн бүрхэг хувь заяа

Анна Эдни

Вэйпинг буюу зай хураагуураар ажилладаг цахим тамхины хэрэглээ ихэссэн нь олон нийтийн эрүүл мэндийг хамгаалагчдын дунд сүүлийн жилүүдэд ширүүн маргаан дэгдээлээ. Хэрэглэгчдийн зарим нь вэйп хэрэгсэлээ утаат тамхинаас аюулгүй хэмээн ойлгож явахад нөгөө хэсэг нь амьсгалын замын нууцлаг, ноцтой өвчинд нэрвэгдэж эхэллээ.

ВЭЙПИНГ ГЭЖ ЮУ ВЭ

Вэйпинг нь утаат тамхинд байдаг донтуулдаг алкалоид – никотиныг тамхи асаахад үүсдэг утаа, давирхайгүйгээр биедээ шингэх орчин үеийн арга. Вэйпинг хэрэгсэл доторх зай хураагуур бүхий өчүүхэн төхөөрөмж никотины найрлагатай шингэнийг халааж уур үүсгэдэг бөгөөд энэхүү уураар хэрэглэгч амьсгалж уушгиндаа шингээдэг. Juul зэрэг нийтэд түгээмэл зарим вэйпинг төхөөрөмж насанд хүрээгүй хүүхдийн гарын алганд багтахуйц жижигхэн хөөрхөн хийцтэй, аав ээж, багшаасаа нууцлан ханцуй юм уу цамцны захан дотроо татаад явж болохоор. Вэйп төхөөрөмжийн цэнэглэх шингэн нь манго жимснийхээс авахуулаад төрөл бүрийн амтлаг үнэрт найрлагатай.

УТААТ ТАМХИНААС ИЛҮҮ АЮУЛГҮЙ ЮУ

Цахим тамхи нь утаат тамхи тагагчдыг эрүүл мэндэд их хортой дадал заншлаа арай бага хортойгоор

солих арга гэсэн сурталчилгаа элбэг. Гэтэл вэйпинг нь улам олон хүнийг өвчин эмгэгтэй болгож байгаа нь саяхнаас тодорч эхэллээ. Вэйпийн уур амьсгалснаас болж уушгины учир битүүлэг өвчнөөр энэ зун АНУ-д зургаан хүн эрсдэж, олон зуун хүн эмгэг өвчтэй болов. Ихэвчлэн залуу, өсвөр үеийн, урьд нь эрүүл саруул байсан олон зуун хүн амьсгалын замын хурц хэлбэрийн өвчний улмаас яаралтай тусламжийн тасагт ирсэн олон зуун тохиолдлыг эмч нар бүртгэлээ. Холбооны болон муж улсуудын мөрдөн шалтагч нар шинэ өвчний учир шалтгааныг тодорхойлохоор ажиллаж байна.

ВЭЙПИНГ ХЭРЭГЛЭЭ ХЭР НИЙТЛЭГ ВЭ

Өнгөрсөн оны байдлаар 11.5 тэрбум ам.доллараар хэмжигдэж байсан вэйп бүтээгдэхүүний зах зээл цар хүрээгээ хурдацтай тэлсээр. Juul-ийн борлуулалт АНУ-д ердөө 2017 онд 6000 гаруй хувиар өсөж 16.2 сая ам.долларт хүрснийг АНУ-ын Халдварт Өвчинд Хяналт Тавих, Урьдчилан Сэргийлэх Төвүүд тооцоолжээ. АНУ-д 18-аас доош насныханд вэйп бүтээгдэхүүн борлуулахыг хуулиар хориглодог ч цахим тамхины хэрэглээ ялангуяа өсвөр үеийнхэн дунд “тахлын хурдацтай” тархаж байгааг FDA-д урьд нь комиссар байсан Скотт Готтлиб анхааруулж байна. АНУ-ын засгийн газрын судалгаагаар, 2017-2018 онд вэйп татах явдал ахлах сургуулийн сурагчдын дунд

78 хувиар өссөн дүнтэй байгаа юм. Мөн хугацаанд дунд сургуулийн сурагчдын дунд вэйпинг 48 хувиар өссөн нь нийт сурагчдын бараг таван хувь болж байна. Уг судалгаанаас үзвэл тамхины төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ залуусын дунд 38 хувиар өссөн нь сүүлийн жилүүдэд буурсан хандлага эргээд ихэссэн хэрэг боллоо. Өдгөө дэлхийн 80 улс цахим тамхины хэрэглээг хуулиар зохицуулж байгаагаас Бразил, Грек, Саудын Араб, Турк, Тайланд энэ төрлийн бүтээгдэхүүний борлуулалтыг бүрэн хориглосон.

АНУ-ын эмийн хангамжид нэвчиж буй хавдар үүсгэгч

СЭТГЭЛ ТҮГШИХ УЧИР

Цахим тамхи насанд хүрэгчдийн зарим хэсгийг илүү уршиг бүхий уламжлалт тамхинаас гарахад нь тус болж байгаа байж мэдэх юм. Нөгөө талаар цахим тамхи нь залуу үеийнхнийг никотины хамааралтай болгох эрсдэл ихэслээ. Үүний зэрэгцээ вэйпинг нь шатдаг тамхитай харьцуулахад эрүүл мэндэд уршиг багатайг багтах урт хугацааны судалгааны статистик хомс хэвээр. Цахим тамхины шингэн эд эсэд гэмтэл учруулж, хорт хавдрыг оролцуулаад төрөл бүрийн эмгэг өвчин бүтээгдэхүүнийг арилгачтай ийм магадлал ихэслээ. Никотины үйлчилгээг хүн төрөлхтөн бүрэн судалж амжаагүй ч ялангуяа өсвөр насныхны тархины хөгжилд сөрөг нөлөөллийг багтах баримт бий.

АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ЮУ ХИЙВ

Өсвөр үеийнхэн дунд хэрэглээ нь ихэссэнтэй уялдан АНУ-ын Хүнс, Эмийн Бүтээгдэхүүний Чанарын Хяналтын Алба (FDA – Food and Drug Administration) амт оруулсан ихэнх цахим тамхины худалдааг вэйп дэлгүүрүүдэд хязгаарласны зэрэгцээ онлайн жижиглэн худалдаагчдад үйлчлүүлэгчдээ 18 хүрсэн эсэхийг шалгаж байх шаардлага тавьдаг болсон. Дөнгөж сая АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын тушаалаар FDA тамхинаас өөр төрлийн амт оруулсан бүх вэйп бүтээгдэхүүнийг зах зээлээс зайлуулах зохицуулалт хэрэгжүүлэхээр боллоо.

Анна Эдни

NDMA (N-Nitrosodimethylamine) буюу нитрозодиметилламин гэгч шар өнгөтэй шингэн бодис усанд уусамхай, үнэр, амтгүй. Адгуус амьтанд хорт хавдар үүсгэдэг нь туршилтаар батлагдчихсан, хүнд хорт хавдар үүсгэх эрсдэлтэй, элгэнд маш аюултай бодисын жагсаалтад ордог. Ганц миллиграмм хүрэхгүй тун нь хулганы эсийг хувирган хорт хавдар үүсгэдэг, хоёрхон грамм нь хүнийг хэдхэн хоногт хөнөөх чадалтай. АНУ-ын Оклахома муж улсын эрэгтэй 1978 онд үерхдэг бүсгүйнхээ ар гэрийнхний уудга ундаанд NDMA холин хөнөөж байв. Канадын оюутан 2018 онд хамт сурдаг найзыхаа алмттай бялуунд мөн энэ бодисыг шахан хордуулсан.

Цагтаа пуужингийн түлшинд нэмэлт хольц болдог байсан NDMA-г өдгөө үйлдвэрлэлд хэрэглэхээ нэгэнт больсон. Гэсэн ч арьс идээлэх, будах, төмөрлөг цугтах, автомашины дугуй, газар тариаланд хортон мэрэгч, шавьж, хөвч устгах бодис үйлдвэрлэх явцад энэхүү хорт бодис ялгарах аюултай. Тэр ч байтугай хлораминаар арилгачтай ундаанд NDMA илэрч болдог. Тамхины утаанд мөн энэ бодис байдаг нь дам тамхидалтаас зайлсхийх ёстойн шалтгаан юм. Утсан, шарсан мах байнга иддэг хүн NDMA-д хордох эрсдэл өндөр.

АНУ-ын Хүнс, Эмийн Бүтээгдэхүүний Чанарын Хяналтын Алба (FDA – Food and Drug

Administration) хүний өдөрт идэх хүнс нэг микрограмм буюу граммыг сая хуваасны нэгтэй тэнцэх NDMA агуулах тохиолдолд аюулгүй гэж үздэг.

Тус зохицуулах байгууллага АНУ-д өргөн хэрэглэдэг цусны даралт бууруулах Valsartan эмээс NDMA илрүүлсэн 2018 оны долдугаар сард заналхнаар уг эмийг үйлдвэрлэдэг гурван компани бүтээгдэхүүнээ эргүүлэн татаж эхэлжээ. Гурван компанид API (Active Pharmaceutical Ingredients) буюу эмийн идэвхт үйлчилгээтэй орцыг нь БНХАУ-ын женерик (generic) буюу патентын төлбөргүй үйлдвэрлэдэг эмийн түүхий эдийн тэргүүлэх үйлдвэрлэгч – Zhejiang Huahai Pharmaceutical Co нийлүүлдэг байжээ. Эрүүлэн татах ажил тэр цагаас хойш нийт 51 удаа өрнөж, 2014 оноос ижил зориулалттай Irbesartan, Losartan гэсэн өөр хоёр ч эмийг үйлдвэрлэдэг давтай 10 компанийг хамарсан. Хорт хольц агуулсан эмийн бүтээгдэхүүн дэлхийн 30 улсын сая сая хүнд аюул заналхийлж байна. Аюултай нь тогтоогдсон зарим Valsartan-ы ганц ширхэг таблетка 17 микрограмм хүртэл NDMA-ын агуулгатай нь 22 килограмм утсан мах идсэнтэй дүйнэ.

Хорт хольц өндөр Valsartan-ыг дөрвөн жилийн турш өдөр бүр хэрэглэсэн 8000 хүн тутамд нэг хүн нэмж хавдраар өвдөх эрсдэлтэй гэсэн

тооцоог FDA гаргасан. Харин Европ тивийн эрүүл мэндийн зохицуулах байгууллага эрсдэлийг илүү өндөр буюу уг эмийг хэрэглэж байсан 3,390 хүн тутмаас нэг нь хавдар тусах эрсдэлтэй хэмээн үзжээ.

АНУ-ын зохицуулах байгууллага хэрэглээн шинээр нэвтрэх эмэнд зөвшөөрөл олгохдоо маш хатуу шаардлага тавьдаг. Компаниуд шинэ эмийн клиник туршилтыг дэдэн жилийн турш хүмүүс дээр туршиж аюулгүйн зэрэгцээ эмчлэх нөлөөтэйг нь батлах ёстой. Гэтэл америкчуудын хэрэглэж буй эмийн 90 хувь нь женерик буюу патентын төлбөргүй үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн. Женерик эм арай хямд мөртөө үйлчилгээ ижил.

Өдгөө дэлхийн эмийн бүтээгдэхүүний API-гийн лавтай 80 хувийг Хятад, Энэтхэгт үйлдвэрлэж байна. Харин АНУ-ын зохицуулах байгууллага тус улсад борлуулж буй эмийн бүтээгдэхүүний нэг ч хүрэхгүй хувийнх нь найрлагад бохир хольц байгаа эсэхийг шалгаж амждаг. FDA нь 2008 онд БНХАУ-д хяналтын гурван оффис байгуулж тоог нь яваандаа олшруулахаа мэдэгдсэн. Гэвч 2014 оны байдлаар тус байгууллага Шанхай, Гуанжоу дахь оффисоо хааж, зөвхөн Бээжин дэх оффисоо үлдээжээ.

Женерик эмийн чанарын хяналт дэлхий нийтийг хамарсан бэрхшээл болж хувирлаа. Valsartan-ыг эргүүлэн татсан нь химийн үйлдвэрлэлийн салбарт олон сараар, зарим тохиолдолд олон жилээр нуугдмал явдаг алдаа илэрсэн олон жишээний нэг юм. “Valsartan ердөө л ганц тохиолдол. Өөр ямар юм нуугдаж байгааг хэн мэдэх вэ” хэмээн урьд нь FDA-д эмийн хяналтын ажилтан байсан, өдгөө эмийн бүтээгдэхүүний аюулгүй байдлын зөвлөх Дэвид Гортлер анхааруулав.



Эдийн засаг

ТӨВ БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ

Урсгал дансны алдагдлыг бууруулах шаардлагатай

Энэ оны эцэст төлбөрийн тэнцэл бага зэрэг ашигтай гарах төлөвтэй

Г.Байгал
ЗГМ

Төлбөрийн тэнцлийн алдагдал буурч, төгрөгийн ханш тогтворжих нөхцөл бүрдсэн энэ үед Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал Б.Батдаваатай ярилцлаа.

-Төлбөрийн тэнцэл энэ оны эхнээс ашигтай гарч, улмаар долдугаар сард 500 гаруй сая ам.долларын алдагдал хүлээгээд байна. Үүний гол шалтгаан юу вэ?

-Төлбөрийн тэнцэл оны эхний хагаст 456 сая ам.долларын ашигтай гарсан. Харин долдугаар сард 535 сая ам.долларын алдагдал

хүлээлээ. Үүнд хоёр үндсэн шалтгаан бий. Нэгдүгээр, манай арилжааны банкуудын төв банкинд хадгалуулж байсан харилцах, хадгаламжийн хэмжээ 370 орчим сая ам.доллараар буурч, энэ мөнгөн хөрөнгө арилжааны банкуудын гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь дансанд шилжсэн. Энэ нь эдийн засгийн үр дагавар гэхээсээ илүү банкуудын хөрөнгийн удирдлагатай холбоотой шилжилт учраас цаашид үргэлжлэхгүй гэж харж байна. Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлсөн хоёр дахь хүчин зүйл нь долдугаар сард урсгал данс 93 сая ам.долларын алдагдалтай гарсан. Ингэснээр оны эхнээс нийт урсгал дансны алдагдал 810 орчим сая ам.долларт хүрсэн. Эдгээр хүчин зүйл төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлсөн.

-Урсгал дансны алдагдал яагаад өсөж байна вэ. Энэ алдагдал удаан үргэлжилбэл бизнесүүдэд ямар нөлөө үзүүлэх бол?

-Урсгал дансны бүтцийг эхлээд



С.Батсайхан / ЗГМ ©

танилцуулах хэрэгтэй. Урсгал данс нь барааны худалдаа, үйлчилгээний худалдаа, анхдагч өрсөлдөх чадвар сул байгааг иргэд, аж ахуйн нэгжүүдийн гадагш төлдөг зээлийн хүү, хөрөнгө оруулалтын орлогын тэнцлийг багтаадаг. 2014 оноос “Оюутолгой”, “Тавантолгой” зэрэг уул уурхайн томоохон төслийн үйл ажиллагаа жигдэрснээр манай улсын экспортын хэмжээ нэмэгдэж, барааны данс ашигтай гарах болсон.

Нарийн мэргэжлийн үйлчилгээний салбарын гадагш чиглэсэн төлбөр нэмэгдэж байна

Харин үйлчилгээний данс, ялангуяа, тээвэр, аялал жуулчлал, нарийн мэргэжлийн үйлчилгээний салбарын гадагш чиглэсэн төлбөрийн алдагдал нэлээн нэмэгдэж байна. Өнгөрсөн онд манай улс үйлчилгээний тэнцэлд хоёр тэрбум ам.долларын алдагдалтай төлсөн. Үүнийг дотор нь задлаад үзвэл тээвэрт 500 орчим сая ам.доллар төлсөн байна. Мөн өмнө нь ашигтай байсан аялал жуулчлалын салбар 2018 онд 410 орчим сая ам.долларын алдагдал дагууллаа. Бизнесийн зөвлөх үйлчилгээ, барилга, инженер гэх зэрэг нарийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээнд нэг тэрбум ам.долларын алдагдал урсгасан

Уул Уурхай Цайрын экспорт буурчээ

Т.Элиса
Шинжээч

Цайрын ханш буурснаас үүдэн энэ оны гуравдугаар улиралд экспорт багассан гэж “Цайрт минерал” компани мэдээллээ. Тус компани оны эхний найман сард нийт 62 мянган тонн цайрын баяжмал экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 10 хувь өндөр дүн аж. Гэхдээ 2019 оны эхний хагас жилд экспорт өндөр байсан бол зөвхөн наймдугаар сарын дүнгээр нийлүүлэлт жилийн өмнөхөөс 14-15 хувиар буурчээ.

Ирэх саруудад тус түүхий эдийн ханш өснө гэж таамаглаж буйгаа “Цайрт минерал” компанийн ерөнхий захирал С.Батхүү онцоллоо. Монголын цайрын экспортын 75 орчим хувийг “Цайрт минерал”, үлдсэн

байна.

Үйлчилгээний данс алдагдал манай улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар сул байгааг илтгэж байгаа. Дэд бүтцийн хөгжил сул. Нарийн мэргэжлийн үйлчилгээг манай дотоодын аж ахуйн нэгжүүд олгож чадахгүй, гадаадаас авч байна гэсэн үг. Гуравдугаарт, манай улсын аж ахуйн нэгж иргэдийн гадагш төлбөр буюу бидний мэргэжлийн хэллэгээр анхдагч орлого. Энэ дүн бага байсан ч гадаад өр, хөрөнгө оруулалтын позицын сөрөг дүн хуримтлагдахын хэрээр зээлийн хүү, хөрөнгө оруулалтын төлбөрүүд нэмэгдээд байгаа.

Өнгөрсөн онд гэхэд Монгол Улс цэвэр дүнгээрээ 1.2 тэрбум ам.долларын алдагдал зээлийн хүү, хөрөнгө оруулалтын төлбөрт төлсөн байгаа юм. Урсгал дансны алдагдал өнгөрсөн жил нийт 2.2 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 17 орчим хувьтай тэнцэж байна. Сүүлийн 10 жилд Монгол Улс жилд дунджаар ДНБ-ий 22 хувьтай тэнцэх хэмжээний урсгал дансны алдагдал хүлээж байна.

Дэлхийн банкнаас өнгөрсөн жил гаргасан судалгаагаар нийт 100 гаруй орны урсгал дансны тэнцлийн хамгийн их алдагдалтай эхний гурван улсын тоонд Монгол Улс багтсан. Тиймээс Монголбанкнаас урсгал дансны алдагдлыг бууруулах чиглэлээр бодлогын арга хэмжээ авах, олон улсын байгууллагуудтай хамтрах, эрдэмтэн судлаачидтай санал солилцох зэрэг үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээнд нэг тэрбум ам.долларын алдагдал урсгасан

17-нд “Төлбөрийн тэнцэл ба гадаад өр” сэдэвтэй хэлэлцүүлэг зохион байгуулах гэж байна. Хэлэлцүүлгээр урсгал дансны алдагдлыг төсөв, мөнгөний бодлого талаас яаж бууруулах, эдийн засгийн урт хугацааны бүтцийн өөрчлөлт, өрсөлдөх чадварын чиглэлээр ямар ажил хийж болох зэргийг хэлэлцэх юм.

-Хэрэв гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилтэд саатал учирвал урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлэх үү?

-Урсгал дансны алдагдал сүүлийн 10 жилд дунджаар ДНБ-ий 22 хувьтай тэнцэж байгааг дээр дурдсан. Үүнийг бид гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээлийн эх үүсвэрээр нөхөж байгаа. Хэрэв хөрөнгө оруулалтын болон зээлийн орох урсгалаа эдийн засгийн үр ашигтай салбаруудад зарцуулж чадвал ирээдүйд өндөр бүтээмжтэй салбарууд маань эргээд экспортоор урсгал дансны алдагдлыг бууруулах бүрэн боломжтой. Гэхдээ сүүлийн 5-6 жилийн нөхцөл байдлыг харвал гадаадын шууд хөрөнгө оруулалт төдийлэн өсөхгүй байна.

2010-2012 онуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт 4.5 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 45 орчим хувьтай тэнцэж байсан. Өнгөрсөн жил гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.2 тэрбум ам.доллар, энэ оны эхний долоон сарын байдлаар 1.1 тэрбум ам.доллартай тэнцүү байна. Үүнийг задлаад харвал “Оюутолгой”-н хөрөнгө оруулалт 80 хувийг нь бүрдүүлж байгаа юм. Бусад хөрөнгө оруулалт бага хувийг эзэлж байна. Бидний харж байгаагаар энэ оны эцэс, ирэх онд томоохон дүнтэй гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх төлөвгүй. Монголбанк Олон улсын санхүүгийн корпорац, Үндэсний хөгжлийн газартай хамтран ирэх сард хөрөнгө оруулалтын орчны хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж байгаа. Үүгээр хөрөнгө оруулалтын орчин ямар байна вэ, хөрөнгө оруулалт манай эдийн засгийн өсөлт, бүтээмж, технологийн дэвшилд ямар үр ашигтай болохыг хэлэлцэх юм.

-Энэ оны эцэст төлбөрийн тэнцэл ашигтай гарах боломж бий юу?

- Энэ оны эцэст төлбөрийн тэнцэл бага зэрэг ашигтай гарах болов уу гэж хүлээж байна. Гол нөлөөлж буй хүчин зүйл нь экспортын орлого нэмэгдэж байна. Эхний долоон сарын байдлаар экспорт өмнөх оны мөн үеэс 11 хувь буюу 450 орчим сая ам.доллараар нэмэгдсэн. Энэ нь нүүрс, төмрийн хүдрийн үнэ өссөнтэй холбоотой. Оны эцэст төлбөрийн тэнцэл 300-400 сая ам.долларын ашигтай гарах болов уу гэсэн хүлээлттэй байна.

ЗГМ ТОВЧХОН

» ТАВААР

483.5

Ам.доллар. Олон улсын зах зээлд нэг бушель буудайн үнэ 0.05 хувиар буурч, 483.5 ам.доллартай тэнцэж байна.

» ТҮҮХИЙ ЭД

0.4

Хувь. Олон улсын зах зээлд WTI төрлийн газрын тосны ханш 0.4 хувиар уруудаж, 54.8 ам.долларт хүрсэн бол Brent-ийн үнэ 0.2 хувиар багасаж, 60.2 ам.доллар болов.

» МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

17

Хувь. Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт (M2) наймдугаар сарын эцэст 20.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өслөө.

» БАНК САНХҮҮ

1.8

Тэрбум төгрөг. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө өнгөрсөн сарын эцэст 925.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

» ГАДААД ХУДАЛДАА

70

Хувь. АНУ, Ираны гадаад худалдааны эргэлт энэ оны эхний долоон сарын хугацаанд 70 хувиар буурсан.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

1.1

Тэрбум төгрөг. “Сүү” хувьцаат компани 2018 оны цэвэр ашгаасаа нэгж хувьцаанд 3.33 төгрөгийн ногдол ашиг тараахаар болов. Тус компани нийт 1.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хэлбэрээр хуваарилна.

» ХУВЬЦАА

41

Сая төгрөг. Монголын хөрөнгийн биржийн баасан гарагийн арилжаагаар 19 хувьцаат компанийн 41 сая төгрөгийн үнийн дүн бүхий 215,099 ширхэг хувьцаа арилжлаа.

» АРИЛЖАА

14

Хувь. “Хай Би Ойл” компанийн хувьцааны ханш 14 хувиар дээшилж, Монголын хөрөнгийн биржийн арилжааг үнийн өсөлтөөр тэргүүллээ. Харин “Өндөрхаан”, “Материалимпекс” компанийн хувьцааны ханш тус бүр 14 хувиар уруудсан нь огцом уналтад тооцогдож байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2,670.87
Евро	2,962.93
Японы иен	24.74
ОХУ-ын рубль	41.42
БНХАУ-ын юань	377.27
БНСУ-ын вон	2.27

Эдийн засаг



Мазаалай бондын 600 сая ам.доллар, 2022 оноос Чингис бондын нэг тэрбум ам.доллар гээд 2024 он хүртэл тулсан эргэн төлөлтүүд шил шилээ дарна. Нийт 2.9 тэрбум ам.долларын өр биднийг хүлээж байна.

Гадаад өрийн зөрүүтэй мэдээлэл эргэлзээ үүсгэж байна

С.Батсайхан / ЗГМ©

Засгийн газрын гадаад өр 7.6 хувиар өсөж, 22.7 их наяд ам.долларт хүрэв

Бизнесийн орчин доройтсон, авлига гаарсан оронд өрийн хэмжээ дорвитой буурдаггүй аж. Үүнийг Латин Америк, Венесуэл, Зимбабве тэргүүтэй орны бодит жишээнээс харж болох юм. Монгол ч үүний тод жишээ болж байна. Өрийн ангалаас бид хараахан гараагүй болохыг 2021 оноос залгах бондын их өрүүд сануулна.

Манай улсын нийт өр ДНБ-ий 220 хувьтай тэнцэж байна. Үүнээс гадаад өрөө салгаж харвал, ДНБ-ий 58.9 хувьд хүрчээ. Гадаад өрийн хэмжээ өнгөрсөн хугацаанд буурч гавьсангүй. Төв банкны зарласан албан ханшаар ам.доллар 2670 төгрөгтэй тэнцэж, сүүлийн нэг жилийн хугацаанд тасралтгүй өсөв. Ам.долларын нэрлэсэн ханш төгрөгийн эсрэг чангарах хэрээр манай улсын гадаад өрийн хэмжээ тэлсээр. Сангийн сайдын мэдээлснээр, Засгийн газрын өр ДНБ-ий 78.8 хувийг 2016 оны төгсгөлд эзэлж байсан бол энэ хэмжээ өнгөрсөн оны төгсгөлд ялимгүй буурч, дээрх түвшинтэй ойролцоо ирсэн билээ.

Гэвч Засгийн газар, НҮБ, Дэлхийн банк, ОУВС, төв банкны гадаад өрийн статистик хоорондоо үргэлж эөрж байна. Хэнд нь итгэх



вэ гэсэн эргэлзээ үүсэхэд хүрээд байна. Ирэх 2021 оноос манай улс томоохон бондуудын өр төлж эхэлнэ. Мазаалай бондын 600 сая ам.доллар, 2022 оноос Чингис бондын нэг тэрбум ам.доллар гээд 2024 он хүртэл тулсан эргэн төлөлтүүд шил шилээ дарна. Нийт 2.9 тэрбум ам.долларын өр биднийг хүлээж байна.

Гадаад валютын албан нөөц сүүлийн гурван жилийн хугацаанд тасралтгүй нэмэгдэж 3.5 тэрбум ам.долларыг давсан. Хэдий тийм боловч алт тушаалт энэ оноос буурснаар валютын нөөц тогтвортой нэмэгдэх баталгаа үгүй болчихлоо. Энэ оны эхний найман сарын байдлаар алт тушаалт 9.6 тонн болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 хувиар буурчээ.

Хариуцлагатай, хариуцлагагүй уул уурхайг ялгаж, салгаж ойлгохын оронд нийтээр нь төр маань ниргэх болсноор энэ оны хоёрдугаар хагаст алтны хэд хэдэн томоохон уурхай хаагдаж, алт тушаалт огцом буурах хүлээлттэй байна. Валютын нөөц энэ байдлаар цаашид багассаар байвал бондуудын эргэн төлөлтийн явцад эдийн засагт хямралын шинжтэй хүндрэл үүсэж болзошгүй зарим эдийн засагч анхааруулсаар. Гадаад өрийн дарамт өндөр байгаа нөхцөлд 2020 оны улсын төсвийг зөвхөн сонгуульд зориулж бус ихээхэн ухаалаг төлөвлөх цаг үе ирлээ. Сангийн яамны мэргэжилтнүүд ирэх оны төсвийн төслөө боловсруулж хэдийн эхэлсэн. Мөнгөний бодлогын төсөл ч төсөвтэй зэрэгцэн УИХ-д орж ирнэ. Эдгээр бодлогын баримт

бичигт өрийн эргэн төлөлттэй холбоотой чухал заалтууд багтах биз ээ.

● Гадаад өрийн дарамт өндөр байгаа нөхцөлд 2020 оны улсын төсвийг зөвхөн сонгуульд зориулж бус ихээхэн ухаалаг төлөвлөх шаардлага үүслээ.

● Улсын өрийн шинэ статистикт анхаарал татаж байна. Улсын гадаад өр оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өсөж, 29.7 тэрбум ам.долларт хүрсэн байна.

● Гадаад өрийн энэхүү зөрүүтэй байдлын талаар Сангийн яамнаас тодруулсан боловч “Сайдаас өөр хүн энэ талаар албан ёсны байр суурь илэрхийлэхгүй” гээд гэдийчихлээ.









Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, эрдэс бүтээгдэхүүний үнэ, экспортын хэмжээ харьцангуй таатай байснаар оны эхний найман сард төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 549.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн тэнцлийн ашиг өмнөх

оны мөн үеэс 34 хувиар өсжээ. Ашиг, өсөлт аль аль нь эдийн засагт сайн үзүүлэлт. Үүнтэй хамт нэгэн тааруу мэдээг давхар дуулгая.

Улсын өрийн шинэ статистикт анхаарал татаж байна. Улсын гадаад өр оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өсөж, 29.7 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс Засгийн газрын гадаад өр өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өсөж, 22.7 их наяд ам.долларт хүрэв. НҮБ-ын шинжээч сэтгүүлч нартай уулзсаны дараахан Үндэсний статистикийн хороо нийгэм, эдийн засгийн тайлан гарч, өрийн хэмжээ албан ёсоор тодорхой болжээ. Засгийн газрын зүгээс гадаад өрийн хэмжээ буурч байна гэх боловч төрийн статистик боловсруулах мэргэжлийн байгууллагын мэдээллээр, гадаад өр 29.7 тэрбум ам.долларт хүрч, нэмэгдчихээд байна.

Азийн хөгжлийн банк, ОУВС манай улсын гадаад өрийн эрдэдлэд ихээхэн санаа зовниж, нөхцөл байдлыг анхааруулж буй. Гэтэл Засгийн газар гадаад өр буурч байна, өрийн дарамт холдож байна гэж сурталчлах нь хэтэрсээр. Ядаж Үндэсний статистикийн хорооны мэдээллээ авч харах цаг болжээ. Гадаад өрийн энэхүү зөрүүтэй байдлын талаар Сангийн яамнаас тодруулсан боловч “Сайдаас өөр хүн энэ талаар албан ёсны байр суурь илэрхийлэхгүй гээд гэдийчихлээ. Өр зээл тавихдаа манай албаныхан туйлын найрсаг загнан авч эргээд төлөх цаг дор өрийн тооцоо дээрх байдлаараа алдаж мэдэхээр байна. [ЗГМ]

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:



DOW JONES 0.14%	S&P 500 0.072	FTSE 100 0.31%	NIKKEI 225 1.05%	TOPIX 0.93%	SHANGHAI COMPOSITE 0.75%	HANG SENG 0.98%	KOSPI 0.84%
---------------------------	-----------------------------	--------------------------	----------------------------	-----------------------	------------------------------------	---------------------------	-----------------------